- a. Баривчлах, цагдан хорих, саатуулах үед хүч хэрэглэхийг зөвхөн зайлшгүй шаардлагатай тохиолдолд, бусад арга хэрэгсэл үр дүнгүй байх эсвэл төлөвлөсөн үр дүнд хүрэхгүй нь тодорхой болсон үед л зөвшөөрнө. Энэ нь хууль ёсны, пропорциональ байх ба, хуулийн үндэслэлтэй зорилгын төлөө хүний амьд явах эрхийг үргэлж дээдлэх ёстой.
 - b. Үхлийн аюул багатай зэвсгийн хэрэглээг үргэлж анхааралтай үнэлж, хянах ёстой. Галт зэвсгийг хууль ёсны зорилгоор зайлшгүй шаардлагатай, эсвэл зорилгодоо хүрэхэд наад захын арга хэрэгсэл хангалтгүй байхаас бусад тохиолдолд хэрэглэж болохгүй.
 - c. Бие махбодын шийтгэл болон гав, гинж, хөлийн дөнгө, цахилгаан бороохой зэрэг хэрэгслийг ашиглах нь угийн өвдөлт үүсгэх, хүний нэр төрийг гутаан доромжлох шинжтэй тул үргэлж хориглодог.
 - d. Хамгаалах хэрэгсэл, аргыг зөвхөн эцсийн арга хэрэгсэл болгон ашиглах ёстой; тэдгээр нь хувь хүний эрсдэлийн үнэлгээнд үндэслэсэн байх ёстой; аюулгүй байдлын хууль ёсны зорилгод хүрэхийн тулд тэдгээр нь хамгийн бага хөндлөнгийн оролцоотой байх ёстой; тэдгээрийн ашиглалтыг хуулиар зохицуулсан байх, бүртгэдэг байх ёстой; тэдгээрийг хэзээ ч шийтгэл болгон ашиглаж болохгүй бөгөөд шаардлагагүй болсон даруйд нь хасна.



- e. Эрх чөлөөгөө хасуулсан хүн бүрийн албан ёсны бүртгэлийг системтэйгээр, эмх цэгцтэй хөтөлж, тогтмол шинэчилдэг байх.
 - f. Ганцаарчлан тусгаарлах шийтгэл нь хуулийн хатуу зохицуулалттай байх ёстой. Үүнийг зөвхөн онцгой тохиолдолд эцсийн арга хэмжээ болгон, хамгийн богино хугацаанд, зөвхөн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр хэрэглэнэ. Энэ нь дараалсан 15 хоногоос хэтрэхгүй бөгөөд сэтгэцийн эмгэгтэй хүн, хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдэд хэрэглэхийг хориглоно.
 - g. Сахилгын шийтгэл нь хүний нэр төрд нийцсэн, хууль ёсны бөгөөд пропорциональ, процедурын шаардлагын дагуу олгосон, зохих ёсоор бүртгэгдсэн байх ёстой.
41. Хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх нь бүх хүний бие махбодын болон оюун санааны бүрэн бүтэн байдлыг хамгаалахад үндсэн үүрэг гүйцэтгэдэг. Чөлөөтэй байх эрх нь хэнийг ч дур зоргоороо баривчлах, цагдан хорихгүй байхыг шаарддаг. Хүчээр алга болгох, нууцаар саатуулах, удаан хугацаагаар баривчлан хорих зэрэг үйлдлүүд нь дур зоргоор шинжтэй бөгөөд олон улсын хуулийн дагуу ямар ч үед туйлын хориглосон.
42. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэжигтэн, яллагдагчаар татагдсан хүмүүс ихэвчлэн хорих ялаар шийтгүүлдэг. Эрх бүхий албан тушаалтнууд эдгээр хүмүүстэй олон улсын эрх зүйн стандарт, тэр дундаа НҮБ-ын Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм (Нелсон Манделагийн дүрэм)-д заасны дагуу хүнлэг харьцаж, цагдан хорих нөхцөлийг эдлэхийг баталгаажуулах ёстой.
43. Аливаа баривчилгаа, эрх чөлөөг хасах ажиллагаа нь хууль ёсны бөгөөд хууль тогтоомжид хатуу заасан, олон улсын эрх зүйд нийцсэн үндэслэл, журмын дагуу, тухайлбал, шүүхийн шийдвэр, магадлалын үндэслэлийн дагуу явагдах ёстой. Баривчлах, эрх чөлөөг хасах аливаа тохиолдол зайлшгүй шаардлагатай, пропорциональ, эцсийн арга хэмжээ байх ёстой. Мэдүүлэг авах эсвэл мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх нь цагдаа, шүүхийн байгууллагад хэн нэгний эрх чөлөөг хасах хангалттай хууль ёсны үндэслэл болохгүй.
44. Аливаа хүнийг баривчлах, цагдан хорих шийдвэр гаргахдаа хувь хүний тодорхой нөхцөл байдалд үндэслэсэн байх ёстой бөгөөд тухайн хүн оргон зайлах, нотлох баримтыг устгах, нөлөөлөх эрсдэлтэй, эсвэл гэмт хэрэг дахин үйлдэх магадлалтай гэдэгт итгэх үндэслэлтэй байх ёстой. Эрсдэлийг хориhoос өөр төрлийн хорих ял хэрэглэх замаар бууруулж болох ямарваа арга байгаа эсэхийг холбогдох байгууллагууд нь судлах хэрэгтэй. Сэжигтэн, яллагдагчийг тодорхой эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн, хэр хэмжээг нь тааруулсан, ялгаварлан гадуурхахгүй арга хэмжээ авах тохиолдолд суллах шаардлагатай байж болно. Батлан даалтад гаргах гэх мэт арга хэмжээ ногдуулж болох боловч тодорхой эрсдэлийг бууруулахад шаардлагатай хамгийн бага хязгаарлалтыг ялгаварлалгүйгээр авах ёстой.



45. Гэм буруугүйн таамаглал нь сэжигтэн, яллагдагчийг шүүхээр гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцохыг хэлнэ. Гэм бурууг үндэслэлтэй, хөдөлбөргүй нотлох үүрэг нь прокурорын байгууллагад оногддог бөгөөд шүүх хуралдаанд нотлох баримт дээр үндэслэн нотлох ёстой гэсэн үг юм. Мэдүүлэг авах ажиллагаанд ярилцагч этгээд нь энэхүү зарчмыг баримтлан ажилласнаар цуглуулсан мэдээлэл нь үнэн зөв, найдвартай байх магадлалыг нэмэгдүүлж, хууль ёсны бөгөөд шүүхэд ашиглах боломжтой нотлох баримтыг бүрдүүлнэ.
46. Гэм буруугүй байх таамаглалын салшгүй хэсэг нь дуугүй байх, албадлагаар өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхөөс хамгаалагдах эрх юм. Энэ эрх нь мэдүүлэг өгч буй хүн эрх бүхий этгээдэд мэдүүлэг өгөхдөө албадлагаар өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх болон бусад шалтгаанаар хариулт өгөх, тайлбар хэлэхээс татгалзах эрхийг баталгаажуулдаг. Сэжигтэн, яллагдагч дуугүй байх нь шүүхээр гэм буруутай, гэм буруугүйг эцсийн байдлаар тогтооход ямар ч нөлөө үзүүлэхгүй бөгөөд гэм буруугүй гэж үзэх эрхэд нөлөөлөх ёсгүй.
47. Эрх бүхий этгээд ярилцлагад орсон бүх хүнд ямар нэгэн сөрөг нөлөөгүйгээр эрх, эрх чөлөөгөө эдлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид хандах баталгааг хангах ёстой. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх чөлөөг үр дүнтэй хэрэгжүүлснээр ярилцлагад орсон бүх хүн хуулийн өмнө эрх тэгш байх, тэдэнд тулгарч болзошгүй эмзэг нөхцөл байдлыг зохих ёсоор харгалзан үзэж, тусгайлан хамгаалж, хүндэтгэлтэй хандах баталгаа хангагдана.
48. Энэ хэсэгт заасан эрх зүйн үндсэн зарчмууд нь зүй бус харьцах болон бусад хүчирхийллээс хамгаалах хэд хэдэн үндсэн хууль эрх зүйн болон процедурын баталгааны үндэс суурь болдог. Эдгээр хамгаалалтууд нь ярилцлагын цогц үйл явцын салшгүй хэсэг юм; үр дүнтэй ашигласнаар ярилцлага авагч нь хүний эрхийг хамгаалах, ярилцлага авах ажиллагааны шударга байдлыг хангаж ажиллаж чаддаг.

Мэргэжлийн ёс зүйн үндэс

49. Үр дүнтэй ярилцлага авагч этгээд нь ёс зүйн хамгийн дээд хэм хэмжээг баримтлах ёстой. Хууль сахиулах болон бусад мэдээлэл цуглуулах эрх бүхий байгууллагад зориулсан журам нь ёс зүйн дүрэм буюу мэргэжлийн зан үйлийн зорилго, үнэт зүйл, хүлээлтийг тодорхойлсон байна. Эдгээр мэргэжлийн стандартууд нь бүх асуудлыг олон улсын эрх зүйн үүргийн дагуу албан тушаалтны үүрэг, түүний дотор ярилцлагыг зохицуулах ёстой.
50. Ярилцлага авагч бүр ёс зүйтэй ярилцлага хийх үүрэгтэй байх ёстой. Тэд асар их дарамттай байсан ч өөр шалтгаанаар энэ зарчмыг золиосолж болохгүй (жишээ нь, цаг хугацааны хязгаарлалт эсвэл үр дүнгийн шаардлагын



- улмаас). Ярилцлага авагчид эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ хуульд заасны дагуу ёс зүй, шүүх болон олон нийтийн хяналтад нийцэх, найдвартай үр дүнд хүрэхэд зорих ёстой.
51. Хүндэтгэл, шударга ёс, үнэнч шударга байдал нь бүх ярилцлагын үндэс суурь болохыг Хууль сахиулах байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэмд онцлон тэмдэглэсэн байдаг:
- a. Хүндэтгэл гэдэг нь хууль тогтоомж, хүний эрх, нэр төр, мэдээлэл цуглуулах үйл явцын шударга байдлыг хүндэтгэх явдал юм. Мөн ярилцлага өгч буй хүний үг хэлэх эсэхээ сонгох эрх зэрэг бие даасан байдлыг хүндэтгэх явдал.
 - b. Шударга ёс гэдэг ойлголтод ярилцлага авагч нь ярилцаж буй хүмүүсийнхээ хэн нэгэнд давуу байдал олгохгүй байх, ялгаварлан гадуурхахгүйгээр шударгаар хандахыг хэлнэ. Шударга ёс нь өөртөө байнга хяналттай байж, өдөөн хатгалгад өртсөн ч хувийн бүх үзэл бодлыг хойш тавьж, мэргэжлийн түвшинд ажиллах явдал юм.
 - c. Үнэнч байдал гэдэг нь ярилцагчтай чин сэтгэлээсээ, үнэнчээр харилцахыг хэлнэ. Ярилцлага авагч нь ярилцаж буй хүнийг худал хуурмаг, төөрөгдөл, хэтрүүлсэн үг, хэсэгчилсэн үнэн болон бусад арга хуурч мэхлэхгүй байх явдал нь үнэнч байдал юм.
52. Ямар ч үед албан тушаалтнууд төрийн эрх мэдлийг хууль ёсны дагуу, шударгаар, хариуцлагатай хэрэглэх ёстой. Албан тушаалын хувьд хууль бус үйлдэл хийсэн бол эрх мэдлээ хэтрүүлсэн хэрэг болно. Худал хэлэх, залилан мэхлэх зэрэг ёс зүйгүй үйлдэл нь эрх мэдлээ урвуулан ашигласан хэрэгт тооцогдоно.
53. Ярилцлага авагч нь ярилцаж буй хүний эрх, эрх чөлөө, нэр төрийг хамгаалах, үйл явцын шударга байдлыг хамгаалах хамгийн үр дүнтэй аргыг хэрэглэх ёс зүйн үүргийг хүлээнэ. Ярилцлага авагч нь үнэн зөв мэдээлэл авах зорилгыг алдагдуулах, ярилцаж буй хүнд хохирол учруулах, хүний эрхийн зөрчилд хүргэж болзошгүй албадлагын арга барилаас татгалзах үүрэгтэй.



ХОЁРДУГААР ЗАРЧИМ ДАДЛАГАД СУУРИЛАХ

Үр дүнтэй ярилцлага нь холбогдох хууль эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ үнэн зөв, найдвартай мэдээлэл цуглуулах цогц үйл явц юм.



Цогц үйл явц

54. Үр дүнтэй ярилцлага нь нэг үйл явдал биш, харин цогц үйл явц юм. Энэ нь мөрдөн шалгах болон мэдээлэл цуглуулах эрх бүхий байгууллагуудын ярилцлага хийх хүмүүстэй харилцах бүх харилцааг хамарч, тухайн хүнийг мэдээлэл авах хүн мөн болохыг холбогдох албан тушаалтан тогтоосон үеэс эхэлж, бодит мэдүүлэг авах ажиллагаагаар үргэлжилж, тухайн үйл явцыг үнэлж, үр дүнд нь дүн шинжилгээ хийсний дараа дуусгавар болно. Ярилцлага авагч аливаа ярилцлага хийхээс өмнө, хийх явцад болон дараа нь ярилцаж буй хүнтэй хэрхэн харьцах нь ярилцлагын үйл явцын шударга байдалд чухал үүрэгтэй.
55. Ярилцлага нь хүн, хүний зан төлөв, хүний эрхийг хамарсан дасан зохицох цогц үйл явц юм. Энэ үйл явц нь хүрээлэн буй орчны нөхцөл байдал, үр дагаварт нөлөөлдөг. Ярилцлага авагч болон холбогдох бүх эрх мэдэлтнүүдийн үйл ажиллагаа нөлөөлж болдог бөгөөд түүний үр дүнд нь, ярилцлага авагч нь ярилцаж буй хүнээр гэм бурууг нь хүлээлгэхээс илүүтэй, мэдээлэл цуглуулахыг эрмэлзэж, шугаман бус уян хатан хандлагыг баримталдаг. Цаашилбал, ярилцлага бүр өөр өөр байдаг тул ярилцлага авагчид ямар ч тохиолдолд хэрхэн үргэлжлүүлэх эсэхээ шийдэхдээ мэргэжлийн, хамгийн сайн шийдвэрийг гаргах хэрэгтэй.
56. Ярилцлага нь тусдаа ойлголт биш юм; Энэ нь өргөн хүрээний мөрдөн шалгах эсвэл мэдээлэл цуглуулах ажиллагааны хүчин чармайлтын нэг хэсэг юм. Ярилцлагын үеэр цуглуулсан мэдээллийг өргөн хүрээний мөрдөн шалгах ажиллагааны зорилго, стратегийг тохируулах, тэр ч байтугай шинэ мөрдөн шалгах ажиллагааны чиглэлийг гаргаж ирэхэд ашиглаж болно. Ярилцлагын үеэр олж авсан мэдээлэл нь ихэвчлэн яллах эсэх зэрэг дараагийн гаргах

шийдвэрийн үндэс, түүнчлэн хууль эрх зүйн болон бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал нотлох баримт болж өгдөг тул чухал ач холбогдолтой юм.

57. Ярилцлагыг үр дүнтэй явуулах үйл явц нь ихэвчлэн дараах зүйлийг агуулна.
- a. Нарийвчилсан бэлтгэл, төлөвлөлт
 - b. Холбогдох хамгаалалтыг бүхэлд нь хэрэгжүүлэхийг баталгаажуулах
 - c. Нээлттэй сэтгэх, ингэхдээ өрөөсгөл ойлголтоос зайлсхийх
 - d. Албадлагагүй орчин бүрдүүлэх
 - e. Харилцаа холбоо тогтоох, хадгалах
 - f. Хууль ёсны бөгөөд шинжлэх ухааны үндэслэлтэй асуулт асуух арга техникийг ашиглах
 - g. Идэвхтэй сонсох, ярилцагчид чөлөөтэй, бүрэн дүүрэн ярих боломжийг олгох
 - h. Цуглуулсан мэдээлэл, ярилцлагын үйл явцыг үнэлэх, дүн шинжилгээ хийх.

Үнэн зөв, найдвартай мэдээлэл

58. Бүх ярилцлагын зорилго нь тухайн ярилцаж буй хүнээс үнэн зөв, найдвартай мэдээлэл авах явдал бөгөөд ярилцлага авагчийн юу болсон байж болох талаарх итгэл үнэмшлийг нотлох, эсвэл ярилцлага өгч буй хүнийг мэдээлэл өгөхийг шаардах хэрэгсэл биш юм. Мэдээлэл цуглуулах үйл явцын дүнд олж авсан үнэн зөв, найдвартай мэдээлэл нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллагууд зөв шийдвэр гаргах үндэс суурь болдог.
59. Ярилцлагаас үнэн зөв мэдээлэл олж авахыг эрмэлзэнэ гэдэг нь ярилцлага авагч нь аль болох үйл явдлын талаарх алдаагүй тайлбар авахыг хэлнэ. Хүний санах ой нь өөрөө эмзэг, төгс бус, бүрэн бус, хурдан саардаг байх бүрэн боломжтой. Иймд ярилцлага авагчид мөрдөн байцаалтын явцад болсон үйл явдлын талаарх мэдээллийг аль болох бодитой, бүрэн гүйцэд, орхигдуулах, гуйвуулахгүйгээр цуглуулж, бүртгэхийг хичээх хэрэгтэй.
60. Аливаа тайлбар, мэдүүлгийг саадгүй, албадалгүй авсан тохиолдолд ярилцлагаас олж авсан үнэн зөв мэдээлэл нь дараа, дараагийн шүүх хуралдаанд шалгагдах, хянагдахад тэсвэртэй, найдвартай байх магадлалыг дэмждэг.



Хууль эрх зүйн хамгаалалтууд

61. Олон улсын эрх зүйн стандартад үндэслэсэн хууль эрх зүйн болон процедурын баталгаа нь ярилцлагын үйл явцын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Ярилцлагын өмнө, дундуур болон дараа нь үүнийг үр дүнтэй ашиглах нь хүний эрхийг хүндэтгэх, олж авсан мэдээллийн найдвартай байдал, нотлох үнэ цэнийг нэмэгдүүлэх замаар үйл явцыг амжилтад хүргэхэд хувь нэмэр оруулдаг. Эдгээр нь мэдээлэл цуглуулах, шүүн таслах ажиллагааны туршид мэргэжлийн, үр дүнтэй ярилцлага хийх, шударга хандах магадлалыг нэмэгдүүлдэг. Иймд эрх бүх албан тушаалтан, тэр дундаа ярилцлага авагч нь хууль зүйн үндэслэлтэй үр дүнд хүрэхийн тулд ярилцлагад оролцогчдод хүндэтгэлтэй хандаж, холбогдох хуулийн стандартыг зохих ёсоор хүндэтгэх нь энэхүү ашиг сонирхолд нийцнэ.
62. Эрх бүхий албан тушаалтан үр дүнтэй ярилцлага хийхдээ дараах хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтийг хангана:
- a. Эрхийн тухай мэдээлэл авах эрх
 - b. Дуугүй байх эрх
 - c. Баривчлах үед баривчлагдсан шалтгаан болон ямар ял тулгаж байгаа талаарх мэдээлэл авах эрх
 - d. Тайлбар тавих эрх
 - e. Цагдан хоригдсон тухайгаа төрөл төрөгсөд, гуравдагч этгээдэд мэдэгдэх эрх
 - f. Өмгөөлөгч, түүний дотор хууль зүйн туслалцаа авах эрх
 - g. Гадаад ертөнцтэй харилцах эрх
 - h. Цагдан хоригдож буй бүртгэл
 - i. Мэдүүлэг авах ажиллагааны бүрэн бүтэн бичлэг
 - j. Мэдүүлгийн тэмдэглэлтэй танилцаж, гарын үсэг зурах эрх
 - k. Шүүгч болон бусад шүүхийн байгууллагад нэн даруй хүргэх
 - l. Үр дүнтэй, хараат бус гомдол гаргах механизм, хяналтад хандах эрх

Ярилцлагын өмнө - албадлагагүй орчныг хангах

63. Ярилцлага авагч болон эрх бүхий албан тушаалтантай харилцах анхны мөчөөс эхлэн хүний эрхийг хүндэтгэж, биелүүлэх нь албадлагын бус орчныг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй. Энэ нь хууль сахиулах, тагнуул, аюулгүй байдал, цэргийн албан тушаалтнуудад ярилцлагын үеэр үнэн зөв, найдвартай мэдээлэл цуглуулах, олон улсын эрх зүйн хүрээнд төрөөс хүлээсэн үүргээ

биелүүлэх, ярилцлага өгөгчийн эрхийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг олгодог.

64. Харилцааны эхний шатанд хууль бус, мэргэжлийн бус зан авир, хариуцлагагүй байдал гаргах нь шүүх ажиллагааны ерөнхий үйл явцыг нэг мөр бусниулж болзошгүй.
65. Стреотип, өрөөсгөл ойлголт нь ярилцлагыг булингартуулж, ярилцлагаас үнэн зөв мэдээлэл олж авахад шаардагдах нээлттэй, харилцан ойлголцолд суурилсан хандлагыг алдагдуулж болзошгүй юм. Ярилцлага авагч нь ярилцлагаас олж авч буй мэдээллийг асуух, тайлбарлах явцад нөлөөлөхөөс урьдчилан сэргийлж, ярилцаж буй этгээдийн хувийн шинж чанар, онцлог байдлын талаарх ухамсартай болон ухамсаргүй төсөөлөл хийхээс татгалзаж, өөрийнхөө танин мэдэхүйн түвшинг илүүтэй ажиллуулах хэрэгтэй.
66. Албан ёсны ярилцлага эсвэл холбогдох хамгаалалтыг төөрөгдүүлэх эрсдэлтэй "албан бус яриа" хийх ёсгүй. Нэгэнт баривчлах шийдвэр гарсны дараа эрх бүхий албан тушаалтнууд ярилцлагад хамрагдах хүмүүсээс албан ёсны ярилцлагаас гадна баривчлах ажиллагаа явуулах, цагдан хорих журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хувийн мэдээлэл, намтар зэрэг хязгаарлагдмал хэмжээний асуулт асуух ёстой.
67. Баривчлах, саатуулах ажиллагааны явцад болон хуулийн дагуух цагдан хорих газарт ирэхээс өмнө хууль бус, хүнлэг бус харьцах эрсдэл ялангуяа өндөр байдаг. Эдгээр ажиллагааны үед үйлдэгддэг хүч хэтрүүлэн хэрэглэх, хязгаарлалтыг буруу ашиглах, гэнэтийн албадан байцаалт авах, тээврийн хэрэгсэлд удаан хугацаагаар саатуулах зэрэг үйлдлүүд нь эрүү шүүлт тулгахтай адилд тооцогдоно.
68. Тухайн хүнийг цагдан хорих шийдвэр гаргасан даруйд эрх бүхий албан тушаалтан хуулийн дагуух цагдан хорих газарт цаг алдалгүй хүргэж өгөх ёстой. Баривчлагдсан хүнийг цагдан хорих байр руу (эсвэл шүүхийн байр гэх мэт өөр байршилд) шилжүүлж, ярилцлага авах ямар ч үед хүнлэг, аюулгүй байдлаар тээвэрлэх ёстой. Баривчлагдсыг аюулгүй тээвэрлэх журамд баривчлагдсан хүн бүрийн тухайд цагдан хорих бүртгэл нээж, эрх чөлөөгөө хасуулсан цаг хугацаа, тэднийг саатуулсан эрх бүхий албан тушаалтан, ирэх үеийн нөхцөл байдал, цагдан хорих газарт хүрэлцэн ирсэн цаг зэргийг бүртгэх, бүртгэлийг зохих ёсоор хөтлөхийг тусгах ёстой.
69. Энэхүү саатуулагдсан эхний цагт зүй бусаар харьцсан эсвэл стандартын бус нөхцөл байдал нь мөрдөн байцаалтын ажиллагаа болон дараагийн ярилцлагад сөргөөр нөлөөлнө: ярилцлагад оролцогчид ярих дургүй байх, танин мэдэхүйн болон бие махбодын сөрөг нөлөөллөөс болж эрхээ бүрэн ойлгох, хэрэгжүүлэх, түүнчлэн үнэн зөв, найдвартай мэдээлэл өгөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй. Энэ үед ярилцлага өгч буй хүний эрх, нэр





төрийг хамгаалах нь албан тушаалтнуудын хуулиар хүлээсэн хариуцлагаас гадна дараагийн бүх үйл ажиллагааны шударга байдлыг хангахад тустай.

70. Мэдүүлэг авахаас өмнө эсвэл авах мэдүүлгүүдийн хооронд тухайн этгээдийг баривчлах бол түүнийг хүний эрхэд нийцсэн нөхцөлд байлгаж, нэр төрийг нь ямагт хүндэлж харьцах, хоол хүнс, ундны ус, өрөөний дулаан, тухтай унтах зэрэг үндсэн хэрэгцээг нь хангахыг эрх бүхий этгээд баталгаажуулах ёстой.
71. Ярилцлага нь хэт урт байх ёсгүй бөгөөд хүний эрхэнд нийцсэн, айлган сүрдүүлэхгүй, нууцлал, аюулгүй байдлыг хангасан орчинд явагдах ёстой. Ярилцлага өгч буй хүний бие махбодын тухтай байдал нь анхаарал төвлөрлийг сайжруулж, харилцаа холбоог сайжруулж, ой санамжийг найдвартай сэргээхэд тустай байдаг.

Ярилцагчдаа мэдээлэл өгөх

72. Харилцааны эхэн үеэс л ярилцлага өгч буй хүний төлөө санаа зовж байгаагаа харуулах нь итгэлцэл, харилцаа холбоог бий болгох анхны боломж юм. Ярилцлага авагчийг ямар албан ёсны баримт бичигт үндэслэн, ямар шалтгаанаар ярилцлагад дуудсан, ярилцлага хэрхэн үргэлжлэх талаар тодорхой тайлбар өгсөн тохиолдолд энэ нь итгэлцэл өгөх магадлалыг бий болгоно. Процендурууд болон цаашид өрнөх магадлалтай үйл явцыг тайлбарлах нь илэн далангүй байдлыг харуулах, урьдчилан таамаглах, хүндэтгэлтэй, халамжтай байх, итгэлцлийг бий болгох анхны боломж юм.
73. Хэн нэгний эрх чөлөөг нь хасахдаа баривчлах эрх бүхий байгууллага тухайн хүнд болж буй үйлдлийг (баривчлах гэх мэт); тухайн үйлдлийг зөвтгөх хууль эрх зүйн буюу бодит үндэслэл; болон тэдний эрхийн талаарх мэдээллийг тодорхой тайлбарлах ёстой. Цагдан хорих байгууллага нь бүхий л үйл явцын дунд тухайн хүн баривчлагдах болсон шалтгаан, эдлэх ёстой эрхийг аль алиныг ойлгосон байх, тухайлбал, шалтгаанд хэрхэн хандах, эдлэх эрхээ хэрхэн утга учиртай эдлэх зэрэг ойлголт өгөх бүх арга хэмжээг авах ёстой.
74. Баривчлах болсон шалтгаан болон аливаа ялын талаар мэдээлэл өгөх нь дур зоргоороо баривчлахаас урьдчилан сэргийлэх баталгаа бөгөөд баривчлагдсан шалтгаан нь үндэслэлгүй, хүчин төгөлдөр бус, хууль бус гэж үзвэл тухайн хүн баривчлагдсан явдлаа хууль ёсны бус болохыг эсэргүүцэж, суллахыг хүсэх боломжийг олгодог. Энэ нь тухайн хүнд цагдан хоригдож байгаа нөхцөл байдал, өөртэй нь харьцах буй хандлагыг өөрчлөхийг уриалж, эрэлхийлэх боломжийг олгодог.
75. Ярилцлага өгч буй этгээдийн эрх, эрхээ хэрхэн эдлэх талаарх мэдээллийг баривчилгааны явцад амаар, ойлгомжтой, техникийн бус хэлбэрээр, нарийвчилсан илэрхийллээр хүргэх; түүнчлэн цагдан хорих газарт ирэхэд нь цагдан хорих байгууллага түүний ойлгох хэл, хэлбэрээр бичгээр өгөх

ёстой. Тэдний эрхийг тодорхойлсон бичмэл маягтад баривчлагдсан этгээд гарын үсэг зурах ба, хуулбарыг өөрт нь хадгалуулахыг зөвшөөрнө.

76. Харааны, сонсголын болон бусад согог зэрэг мэдрэхүйн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулан эрх бүхий этгээдийн ярьдаг хэлээр ярьдаггүй, ойлгодоггүй зэрэг бүх ярилцлагад хамрагдаж буй хүн мэргэжлийн болон бие даасан орчуулагчаар хангагдах ёстой. Ярилцлагын явцад, ялангуяа баривчлагдсан хүмүүсийн эрхийг тэдэнд тайлбарлаж, өмгөөлөгч, эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй уулзах эрхээ хэрэгжүүлэх үед ийм орчуулагчаар нэн даруй хангах ёстой.

Гэр бүл эсвэл гуравдагч этгээдэд мэдэгдэх

77. Баривчлагдсан этгээдийн гол баталгаа бол тэдний гэр бүлийн гишүүн, найз нөхөд, эсвэл өөрийн сонгосон бусад хүнд цагдан хоригдсон баримт, газар, нөхцөл байдлын талаар нэн даруй мэдэгдэх эрх юм. Цагдан хоригдож буй байгууллага нь гуравдагч этгээдтэй харилцах боломжийг олгож, хэнд мэдэгдсэн, хэзээ мэдэгдсэнийг бүртгэх үүрэгтэй. Энэ нь хууль ёсны үүрэг байхаас гадна гадаад ертөнцтэй харилцах харилцааг хөнгөвчлөх, хоригдолтой итгэлцэл, харилцаа тогтоох боломжуудыг олгодог.
78. Эрх бүхий байгууллага гуравдагч этгээдэд мэдэгдэхийг зөвхөн онцгой тохиолдолд, хойшлуулах нь хуульд заасан бөгөөд мөрдөн шалгах явцад гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх (жишээлбэл, нотлох баримтыг устгах, хамсаатан зугтахаас урьдчилан сэргийлэх) шаардлагатай тохиолдолд хойшлуулж болно. Хугацаа хойшлуулсан шалтгааныг нарийвчлан тэмдэглэсэн байх, өмгөөлөгч болон эрх чөлөөгөө хасуулсан этгээдэд хүртээмжтэй байх, прокурор, шүүгч болон бусад холбогдох удирдах албан тушаалтнаар батлуулсан байх, хойшлуулах зайлшгүй шаардлагатай эсэх, түүний пропорциональ байдалд шүүх хяналт тавих ёстой.
79. Баривчлагдсан, саатуулагдсан гадаадын иргэдэд өөрийн улсын консулын болон дипломат төлөөлөгчтэй харилцах эрхийг нь нэн даруй мэдэгдэх ёстой бөгөөд орогнол хүссэн хүмүүст холбогдох олон улсын байгууллагуудтай холбоо тогтоох эрхийг нь мэдэгдэх ёстой. Цагдан хорьж буй эрх бүхий байгууллага холбоо барихад нь туслалцаа үзүүлэх ёстой.

Өмгөөлөгчид хандах эрх

80. Ярилцлагад хамрагдаж байгаа бүх саатуулагдсан хүмүүс өмгөөлөгч авах эрхтэй бөгөөд эрх бүхий байгууллагаас ямар нэгэн мэдүүлэг авахаас өмнө тэдний статус, албан ёсны байдлаас үл хамааран хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулна. Энэ эрх нь эрх чөлөөг хассан үеэс эхлэн хэрэгжинэ.





81. Өмгөөлөгчтэй уулзах эрх нь эрхийг хамгаалах, эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх болон бусад зүй бусаар харьцах зэрэгтэй салшгүй холбоотой бөгөөд хүн өөрийн эсрэг мэдүүлэг өгөхөөс хамгаалахад тусалдаг.
82. Ярилцлагад хамрагдсан хүн өөрийн сонгосон өмгөөлөгч авах, эсхүл шударга ёсны эрх ашигт нийцүүлэн шаардлагатай тохиолдолд үнэ төлбөргүй өмгөөлөгч авах эрхтэй. Тэд ярилцлага хийхээс өмнө өмгөөлөгчтэйгөө хангалттай цаг гаргаж, нууцлалтай ярилцах эрхтэй. Цагдан хорих газрын албан тушаалтнууд өмгөөлөгчийг цаг тухайд нь ирүүлэхэд идэвхтэй оролцох ёстой. (хэрэв ярилцлага авагч нь өөр хүн бол).
83. Ярилцлага авч буй этгээд нь “албан бус яриа” буюу өмгөөлөгчийг байлцуулах хүсэлт гаргах үед нь хийдэг ярилцлагыг мэдүүлэг өгч буй этгээдийг өмгөөлөгчтэйгөө уулзахаас нь өмнө, өмгөөлөгчийн оролцоогүйгээр хийж болохгүй.
84. Ярилцлагад оролцогчид өмгөөлөгч авах эрхээсээ татгалзаж болно. Ярилцлага өгч буй этгээд өмгөөлөгч авахаас татгалзахаар шийдсэн бол энэ нь сайн дурын үндсэн дээр зохих ёсоор бүртгэгдсэн байх ёстой бөгөөд баривчлагдсан этгээд гарын үсэг зурсан байна. Өмгөөлөгч авах эрхээсээ татгалзсан хүн бүр татгалзлыг хэдийд ч цуцалж болохыг тодорхой мэдэгдэх ёстой.
85. Сэжигтнээр мэдүүлэг өвч байгаа цагдан хоригдсон хүүхдүүдийн хувьд өмгөөлөгчийг заавал байлцуулна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах

86. Эрх баригчид асран хамгаалалтдаа байгаа бүх хүний бүрэн бүтэн байдал, эрүүл мэндийг хамгаалах ёстой. Цагдан хоригдсон хүмүүс эрх чөлөөгөө хасуулсан цагаасаа эхлэн эмчтэй уулзах, бие даасан мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдах эрхийг нэн даруй баталгаажуулах ёстой. Мөн цагдан хорих байгууллага нь хоригдож буй хүмүүсийг цагдан хорих бүх хугацаанд эмнэлгийн тусламж авах боломжоор хангах үүрэгтэй.
87. Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн цагдан хорих байранд ирэх үеийн бие, сэтгэцийн байдал, тэр дундаа баривчлах, цагдан хорих газарт хүргэх явцад хүч хэтрүүлэн хэрэглэсэн шинж тэмдэг, гомдол зэргийг эмч, эрүүл мэндийн бусад мэргэжилтэн бүртгэж авна. Баривчлагдсан этгээд хүсэлт гаргавал эсвэл түүнийг эрүүдэн шүүсэн болон бусад хэлбэрээр зүй бус харьцсан гэсэн шинж тэмдэг илэрвэл Станбулын протоколын дагуу бие даасан эрүүл мэндийн үзлэгийг цаг алдалгүй хийх ёстой. Шалгалт явуулж буй эрүүл мэндийн мэргэжилтэн нь хорих, хууль сахиулах байгууллагатай ямар ч хамааралгүй, үйл ажиллагааны хувьд хараат байх ёсгүй. Эмнэлгийн үзлэг дуусах хүртэл мэдүүлэг авах ёсгүй.



88. Эрүүл мэндийн үзлэгийг зохих, хангалттай бэлтгэгдсэн, шударга, хараат бус эрүүл мэндийн мэргэжилтнүүд үнэ төлбөргүй хийх ёстой. Эрх бүхий байгууллага нь үзлэгт хамрагдах хүний сонгосон хүйсийн эмнэлгийн ажилтнаар үзлэг хийлгэхэд анхаарах ёстой. Эмнэлгийн ажилтнууд хоригдож буй хүмүүст үзлэг, шинжилгээ эсвэл эмчилгээний курс хийх бүх хугацааны турш үнэ төлбөргүй мэдээлэл өгч, тэдний зөвшөөрлийг авсан байх ёстой. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэ төлбөргүй мэдээлэл өгч, зөвшөөрлийг нь авахдаа онцгой байдал, хэлбэрээр анхаарч энэ эрхийг нь эдлүүлнэ.
89. Эмнэлгийн бүх үзлэгийг хууль сахиулах байгууллагын ажилтнуудын нүднээс хол, сонсогдохгүй байх орчинд хийх ёстой. Онцгой тохиолдолд, эрүүл мэндийн мэргэжилтэн хүсэлт гаргавал тусгай хамгаалалтын арга хэмжээ авч болно, тухайлбал, дуудахад ойр эсвэл хараанд тусах байрлалд гэхдээ сонсох боломжгүй зайнд офицерыг байрлуулах. Ийм зохицуулалтыг шалгалтын болон цагдан хорих бүртгэлийн аль алинд нь тэмдэглэнэ. Эмнэлгийн үзлэгт хамрагдахдаа ямар нэгэн хязгаарлалт хийхээс зайлсхийх хэрэгтэй бөгөөд энэ нь эмнэлгийн мэргэжилтний хувийн аюулгүй байдлын үнэлгээнд үндэслэсэн байх ёстой.
90. Сэтгэцийн болон бие махбодын эрүүл мэндийн үзлэгийн бүх үр дүнг баримтжуулж, баривчлагдсан этгээд болон түүний өмгөөлөгчид өгч, шаардлагатай бол дараагийн шатны шүүх хуралдаанд гаргаж тавина. Хоригдогч, сэжигтэн өөрийн эрүүл мэндийн үзлэг, эмчилгээний талаарх мэдээлэлтэй танилцах эрхтэй. Эмнэлгийн мэдээллийн нууцлалыг чанд сахих ёстой бөгөөд эмнэлгийн бус ажилтнууд мэдэх шаардлагатайгаас бусад тохиолдолд эмнэлгийн бүртгэл, гэмтлийн тайланд хандах эрхгүй байх ёстой.
91. Мэдүүлэг өгөх гэж буй хүн үүнд бие бялдар, сэтгэл зүйн хувьд бэлтгэгдсэн, тохирсон байх ёстой. Эрүүл мэнд сайн байх нь итгэлцэл, харилцан ойлголцлыг бий болгохоос гадна ой санамжаас мэдээлэл олж авахад илүү хялбар болгодог. Цочролд орсон, сэтгэлээр унасан, ядарсан, согтуу эсвэл бусад байдлаар суларсан мэт харагдах хүнээс ярилцлага авах нь тэдний сэтгэлийг ахин сэвтүүлж чанар муутай мэдээлэл үүсгэхэд хүргэж дараагийн хууль эрх зүйн үйл явцад нотлох баримтыг эсэргүүцэх эсвэл үгүйсгэх эрсдэлтэй. Ярилцлагад орж буй хүний биеийн байдал тохиромжгүй гэж дүгнэсэн эсвэл эмнэлгийн мэргэжилтний зүгээс тухайн этгээдийг ярилцлагад орох боломжгүй гэж зөвлөсөн тохиолдолд ярилцлагаа түр хойшлуулах ёстой.

Ярилцлага авагчийн бэлтгэл

92. Эрх бүхий албан тушаалтан тухайн этгээдийг ярилцлага авах хүн нь хэмээн тодорхойлсон цаг мөчөөс эхлэн ярилцлага авагч нь бэлтгэлээ сайтар хангаж эхлэх ёстой. Ингэж эхлүүлснээр ярилцлагыг ерөнхий мөрдөн



шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагааны хүрээнд авч буй ярилцлагын стратеги болох ёстой.

93. Бүрэн бэлтгэлтэй байх нь ярилцлага авагчийн үр дүнтэй харилцах чадварыг нэмэгдүүлж, найдвартай мэдээлэл олж авах магадлалыг нэмэгдүүлдэг. Төлөвлөлтөд зарцуулсан хүчин чармайлт нь процедурын болон бусад зайлсхийх боломжтой алдааны улмаас хэргийг хэрэгсэхгүй болгох эрсдэлийг бууруулдаг.
94. Ярилцлага эхлэхийн өмнө аль хэдийн цуглуулсан мэдээллийн эрэн сурвалжлах, нотлох үнэ цэнийг нэмэгдүүлэх нь туйлын чухал юм. Ярилцлага авагчид урьд авсан гэрч, хохирогчийн мэдүүлэг, сэжигтний урьд өгсөн мэдүүлэг, шүүх эмнэлгийн дүгнэлт, эд мөрийн баримт, цахим зураг, мэдээлэл гэх мэт аль болох олон нотлох баримт, мэдээллийг авч, нягталж үзэх хэрэгтэй. Ярилцлага авагчид байгаа мэдээллийн хамаарал, найдвартай байдлыг үнэлж, ярилцлагын өмнө болон ярилцлагын явцад бөглөх шаардлагатай мэдээллийн цоорхойг тодорхойлох ёстой.
95. Ярилцлага авагчид ярилцлагад бэлдэх болон бүх үйл явцын туршид 'батламжлах өрөөсгөл хандлагаас' зайлсхийхийн тулд болгоомжтой байх хэрэгтэй. Ярилцлага авагчид өөрсдийн анхны таамаглал, үзэл бодлоосоо илүүтэй нотлох баримт, тайлбарыг, тэр дундаа гэм буруугүйг илтгэсэн тайлбарыг идэвхтэй эрэлхийлэх ёстой. Ярилцлагын туршид мэдээлэл цуглуулах чиг шугамаа ямагт баримталснаар ярилцлага бодитой байдлаа хадгалах болно. Мөн ярилцлагын үеэр судалж буй асуудлын талаарх эргэлзээг тайлах, үндэслэлтэй шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх өөр үндэслэлтэй тайлбаруудыг авч үзэх хэрэгтэй.
96. Ярилцлага бүрд зорилго, асуух тодорхой асуулт, бичлэг хийх горим, цаг хугацаа, ярилцлагын байршил болон өрөөнд байх бусад хүмүүс зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан ярилцлагын төлөвлөгөө шаардлагатай. Үр дүнтэй ярилцлага нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байх ёстой бөгөөд тодорхой зорилгод чиглэгдэх ёстой. Ярилцлага бүр өөр байдаг учир төлөвлөгөө нь уян хатан байдлын элементийг агуулсан байх ёстой ба ингэснээрээ идэвхтэй харилцан солилцоог бий болгож чадна.
97. Ярилцлагын үеэр нотлох баримт, мэдээллийг хэрхэн, хэзээ танилцуулахаа мэдэх нь ярилцлага авагчдын гол үр чадвар байдаг бөгөөд энэ нь ярилцлага авагчийн бэлтгэлийн нэг хэсэг байх ёстой. Боломжит нотлох баримтыг задруулах мөч нь ярилцлага өгч буй этгээдийн хэлсэн зүйлийн найдвартай байдлыг тодорхойлох үр дүнтэй арга байж болно. Хэрэв нотлох баримтыг хэтэрхий эрт танилцуулсан бол дараа нь ярилцлага өгч буй хүний өгсөн аливаа мэдээлэл нь түүний ярилцлагын үеэр олж мэдсэн зүйл эсвэл хэлэх ёстой зүйлээ санасны илрэл биш харин өгөх ёстой хэмээн бодсоны үүднээс хэлсэн байх магадлалтай. Мэдээллийг задруулахад тохиромжтой мөчийг



төлөвлөн зохион байгуулснаар ярилцагчийн ой санамжийг сатааруулах эрсдэлийг бууруулж чадна. Аливаа стратегийн нотлох баримтыг задруулах нь заавал сэжигтний хангалттай хэмжээний мэдээлэл авах эрхийн талаарх үндэсний хууль тогтоомжид нийцсэн байх ёстой бөгөөд баривчлах эсвэл саатуулах үйлдэл нь хууль ёсны эсэхийг харуулахуйц байх ёстой.

98. Бэлтгэл ажилдаа, ярилцлага авагчид нь юу яригдаж байгаа талаар хэрхэн тэмдэглэж авахаа бодож үзэх хэрэгтэй. Ярилцлагын өмнө ярилцлага авагч нь ярилцлагыг хэрхэн бүртгэж авах, үнэ төлбөргүй, мэдээлэлтэй зөвшөөрөл хэрхэн авах талаар ярилцлага өгч буй этгээд болон өмгөөлөгчдөд нь үргэлж мэдээлэх хэрэгтэй.
99. Дуу дүрсний бичлэг нь ярилцлагад анхаарлаа төвлөрүүлэх боломжийг ярилцлага авч байгаа этгээдэд олгодог бөгөөд шүүн таслах ажиллагааны цагийг хэмнэдэг. Ярилцлагын турш дуу дүрсний бичлэг хийх нь зүй бус харьцахаас хамгаалах чухал хамгаалалт болдог. Зөв хийгдсэн тохиолдолд энэ нь ярилцлагын бүрэн бөгөөд маргаангүй гарал үүсэл бүхий бичлэгт тооцогддог. Энэхүү технологийг ашиглах нь зүй бусаар харьцсан гэх гомдлыг шалгахад тус дөхөм болох бөгөөд зүй бус үйлдэл гаргасан гэж байгаа тохиолдолд ярилцлага авагч болон ярилцлага өгөгчийн харилцан тус бүрийн ашиг сонирхолд нийцдэг.
100. Хэрэв бичлэг хийх төхөөрөмж байгаа боловч ашиглаагүй бол тодорхой шалтгаан, үндэслэлийг тэмдэглэнэ. Бичлэгийн талаарх хэлтэс эсвэл агентлагийн бодлогоос бусад аливаа зөрчлийг мөн баримтжуулсан байх ёстой. Ярилцлагын цахим бичлэгийг боломжийн хугацаанд хадгалж, зохих хүмүүст хянуулах боломжтой байх ёстой.
101. Ярилцлага авагчид нь цагдан хоригдсон бүртгэл зэрэг бүхий л талыг ярилцлагад орохоос өмнө магадлах ёстой бөгөөд ингэснээр өмнөх үйл ажиллагаанаас үүдэн одоогийн ярилцлагад учирч болзошгүй нөлөөллийг үнэлэх боломжийг олгоно.
102. Ярилцлага авагч нь хууль ёсны төлөөлөгчтэй ажиллах зэргээр ярилцлага хийхээс өмнөх бүх хамгаалалтыг баталгаажуулах ёстой. Энэ нь ярилцлага авагчийн хүний эрх, нэр төрд хүндэтгэлтэй хандаж байгааг харуулдаг тул ярилцлага өгч буй хүнтэй тогтоох харилцаан дахь хэтийн төлөвт сайнаар нөлөөлж, улмаар найдвартай мэдээлэл олж авахад хувь нэмэр оруулдаг.
103. Ярилцлага авагч нь ярилцлага өгч буй этгээдийн тухайд холбогдох алба хаагчдын өмнө тодорхойлсон хэрэгцээг нь харгалзан үзэх, түүнчлэн эмзэг байдлын нэмэгдүүлсэн нөхцөл байдлыг (ярилцлага авагчийн сэтгэл хөдлөл зэрэг) үнэлж, зохих арга замаар шийдвэрлэхэд бэлтгэх үүрэгтэй. Тухайлбал, оюуны болон сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хууль ёсны



төлөөлөгч, асран хамгаалагчид зэрэг гуравдагч этгээдийг оролцуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай үүсэн гарч ирж болно.

104. Ярилцлагын явцад тайван, өөрийгөө хянах чадвартай байхын тулд ярилцлага авагч нь тухайн асуудлын талаарх сэтгэл хөдлөл, ярилцлага өгч буй этгээдэд хандах хандлагаа байнга удирдах ёстой. Хэрэв энэ боломжгүй мэт санагдвал өөр ярилцлага авагч томилох ёстой.

Ярилцлагын үеэр - Харилцаа холбоо тогтоох, хадгалах

105. Үр дүнтэй ярилцлага авагч нь нөхцөл байдалд зохицох чадвартай, анхааралтай сонсож, энэрэнгүй сэтгэлээр харилцаж, тавьж буй албадлагын бус, хүмүүнлэг, ёс зүйтэй, хууль ёсны асуултууд нь ярилцлага авагч, ярилцлага өгөгч болон мэдээлэл цуглуулах эрх бүхий бүх албан тушаалтнуудын ашиг сонирхолд нийцнэ гэх ёс зүйг баримталдаг. Ярилцлага авагчийн үүрэг бол шийдвэр гаргахад хамгийн сайн мэдээллийг олж авах явдал юм. Гэм буруутай эсэхийг шүүх л тогтоодог.
106. Үр дүнтэй мэдээлэл цуглуулахын тулд харилцаа холбоог хөгжүүлэх нь чухал юм. Ярилцлагын үеэр харилцан ойлголцох нь дараах шинж чанартай харилцааг бий болгож, хадгалахад оршино: хүндэтгэл ба итгэлцэл; шүүмжилдэггүй сэтгэлгээ; түрэмгий бус биеийн хэллэг; анхааралтай байдал ба тэсвэр тэвчээр. Энэ нь ярилцлага хийх явцад дотоод хүчний тэнцвэргүй байдлын үр нөлөөг бууруулдаг.
107. Ярилцлага авагч нь ярилцлага өгөгчтэй чанартай харилцах цаг гаргаж, эдлэх эрх, ярилцлага хийх журмын талаарх мэдээллийг тодорхой өгөх ёстой; шаардлагатай бол хэлмэрч, бусад гуравдагч этгээдийн туслалцааг мэдээлнэ. Хэрвээ ярилцлага өгч буй хүн эрхийнхээ талаар тодорхой ойлголтгүй байгаа мэт санагдвал ярилцлага авагч нь дахин тайлбарлаж, ойлгосон эсэхийг нь баталгаажуулах ёстой. Эрүүгийн хэргийн сэжигтний хувьд ярилцлага өгөгч нь дуугүй байх эрхтэй бөгөөд өгсөн мэдээллийг өөрийнх нь эсрэг нотлох баримт болгон ашиглаж болно гэдгийг сануулах ёстой.
108. Ярилцлагын үеэр байлцсан өмгөөлөгч нь хуулийн эх сурвалж, үйл явцын шударга байдлын гэрч бөгөөд үл ойлголцол, ташаа мэдээлэл, ярилцлагыг хууль бусаар явуулах оролдлого хийхээс хамгаалах үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр үүрэг нь ярилцлагын үеэр цуглуулсан мэдээллийн нотолгооны үнэ цэнийг нэмэгдүүлэхэд тусалдаг.
109. Үр дүнтэй ярилцлага авагч нь өмгөөлөгчтэй хүндэтгэлтэй, мэргэжлийн, ажил хэрэгч харилцаа тогтоох ёстой. Оролцож буй өмгөөлөгч асуулт асуух, тодруулга авах, нотлох баримт шаардах, ярилцлага авагчийн шударга бус

асуулт, зүй бус зан үйлийг эсэргүүцэх, ерөнхийдөө үйлчлүүлэгчийнхээ эрхийг хамгаалах эрхтэй.

110. Ярилцлага өгөгч нь урьд өмнө энэ эрхээсээ татгалзаж байсан ч өмгөөлөгчийг байлцуулахыг шаардсан тохиолдолд өмгөөлөгчийг байлцуулах хүртэл ярилцлагыг түр зогсооно.
111. Ярилцлага авагч нь ярилцлагын туршид ярилцлага өгөгчийн сэтгэцийн болон бие махбодын байдалд анхааралтай хандах ёстой. Тэд хангалттай хугацаанд удаан амрах, хангалттай хоол хүнс, уух зүйлээр хангагдах ёстой.
112. Ярилцлагын эхэнд хүлээлтийг бий болгох нь илүү үр дүнтэй үйл явцыг бий болгоно. Жишээлбэл, ярилцлага авагч нь ярилцагчид ойлгохгүй байгаа эсвэл буруугаар ойлгосон гэж бодож байгаа зүйл байвал хэлэхийг, аль болох дэлгэрэнгүй мэдээлэл өгөхийг, шаардлагатай бол хариулахаасаа өмнө хэсэг хугацаанд цаг авч бодох, хэрэгтэй зүйлээ уламжилж болохыг найрсгаар хэлэх ёстой.

Мэдээлэл цуглуулах арга техник

113. Идэвхтэй сонсох нь ярилцлага авагчийн өгсөн мэдээллийг боловсруулахад тусалдаг. Идэвхтэй сонсох нь ярилцлага авагчийн ярьж буй зүйлийг сонсож байгаа, мөн ойлгохын тулд хүчин чармайлт гаргаж байгааг харуулна. Ярилцлага өгч буй хүний ярьж байгаатай санал нийлэх, эсхүл нийлэхгүй байна хэмээн андуурч ойлгогдож болзошгүй тул ярилцлага авагч нь ярилцлага өгч буй этгээдийг дуу авиа, дохио зангаа, асуулт зэрэг аман болон харааны дохиог ашиглан санамсаргүйгээр хөтлөхгүй байхад анхаарна.
114. Ярилцлагад хамрагдагчийг шалгаж байгаа асуудлын талаар өөрийн оролцоо, мэдэж байгаа, санаж байгаа эсэхээ өөрийн үгээр тайлбарлахыг хүсэж, бүрэн хариулах боломжийг олгох ёстой. Дараа нь мэдээлэл нөхөх эсвэл мэдээллийн зөрүүг тайлбарлуулахын тулд илүү нарийвчлан шалгаж болно.
115. Ярилцлага авагч нь ерөнхийдөө ярилцлага өгөгчийн яриаг таслахгүйгээр өгсөн мэдээлэлд үргэлж анхааралтай хандаж, чухал нарийн ширийн зүйлийг анзаарч, дагаж мөрдөх шаардлагатай тодорхой сэдвүүдийг тодорхойлох үүрэгтэй. Яриаг нь тасалдуулахгүй байна гэдэг нь зохистой үед чимээгүй байх явдал юм. Чимээгүй байх нь ярилцлага авагч ярилцлага өгч буй этгээдэд бодох цаг өгч, илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд хүлээхэд бэлэн байгааг илтгэнэ.
116. Ярилцлагад ашигласан асуултуудын төрөл нь хүссэн зорилго, ерөнхий үр дүнд хүрэхэд тусалдаг. Зорилго нь аль болох сайн дурын, үнэн мэдээлэл авах явдал юм. Асуулт бүр нь зорилготой байх ёстой бөгөөд шүүмжлэхгүй





байх ёстой. Хэрэглэсэн хэл нь тодорхой байх ёстой бөгөөд техникийн нэр томьёо, үг хэллэг, товчилсон үгээс зайлсхийх хэрэгтэй.

117. "Надад тайлбарлаач", "надад хэлээч" эсвэл "тайлбарлаж өгнө үү" гэх мэт нээлттэй орхисон асуултууд нь ярилцагчийн ой санамжийг булингартуулах эрсдэлийг бууруулж; ярилцагч авагчийн нөлөөнд автах магадлалыг бууруулж, илүү дэлгэрэнгүй, бүрэн дүүрэн хариулт өгөхөд чиглүүлдэг.
118. Нээлттэй орхисон асуултад хариулсны дараа илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахын тулд "хэн", "юу", "хаана" гэх мэт тэргүүлэх асуултууд шаардлагатай байж болно. Эдгээр нь нэмэлт холбогдох мэдээллийг олж авах, нэмэлт судалгаа шаарддаг тодорхой цоорхой, зөрчилдөөнтэй байдлыг тодорхойлоход тусалдаг. Ярилцлагад хамрагдсан хүмүүс урьд өмнө дэлгэж байгаагүй зүйлээ ч илчилж болно.
119. Мэдээллийн энэ стратеги нь ярилцлагыг удирдан чиглүүлж, олж авсан мэдээлэл ярилцлагын зорилгод нийцэхэд тусална.
120. Ярилцлага өгсөн хүний ярьсан зүйлийг үнэн зөвөөр хураангуйлах нь ярилцлага сайн ахиц дэвшилтэй явагдахад нөлөөлж, ярилцлага авагч болон ярилцлага өгөгч этгээдүүдийн аль алинд нарийн ширийн зүйлээ эргэн санахад тусална. Харин буруу тэмдэглэсэн хураангуй мэдээлэл нь ярилцлага өгөгчийн өгсөн мэдээллийг булингартуулж, өрөөсгөл, буруу ойлголттой болгож болзошгүй. Ярилцлага өгсөн хүн түүний яриаг сонсохгүй байсан, эсвэл өгөх мэдээллийг нь удирдахыг оролдсон гэж буруу үйлдсэн хураангуйд тайлбар, дүгнэлт өгч болно.

Дургүй байдалтай тулгарах

121. Ярилцагч нь ярих дургүй этгээдтэй таарсан тохиолдолд хэрхэн хандахаа урьдчилан таамаглах ёстой. Хариулахыг хүсэхгүй эсвэл зөвшөөрөхгүй байх нь хувийн сонголт байж болно. Зарим этгээдүүд, тухайлбал, эрүүгийн хэргийн сэжигтнүүд асуултад хариулахгүй байх эрхээ эдэлнэ. Энэ шийдвэрийг үргэлж хүндэтгэх ёстой бөгөөд ярилцлага өгч буй этгээдийн гэм буруутай эсвэл буруугүй байхтай холбоогүй байна.
122. Ярилцлага авагч яагаад ярих дургүй байж болох шалтгаан нь түгшүүртэй байгаагаас, эсвэл өмнөх нөхцөл байдал, үйл явцын талаар мэдээлэлгүй, ялангуяа өмнө хэзээ ч ийм байдалд орж байгаагүй зэргээс үүдэлтэй байж болзошгүй. Айдас ч гэсэн тодорхой үүрэг гүйцэтгэдэг; жишээлбэл, цагдаа болон бусад эрх бүхий албан тушаалтнуудаас айх, эсвэл тэдгээртэй ярилцсан нь мэдэгдвэл өөрсдөдөө болон бусдад сөрөг нөлөө үзүүлэхээс эмээж болно. Ярилцлагад хамрагдагсдын үзсэн, сонссон эсвэл туулсан зүйлүүд сэтгэл зүйд нь нөлөөлсөн ч байж болно. Ярихаас татгалзаж байгаа



нь ярилцлага авагч эсвэл орчуулагчид үзүүлж буй хувийн хариу үйлдэлтэй бас холбоотой байж болох юм.

123. Ярилцлага авсан хүн мэдээлэл өгөх хүсэлтэй ч өгөх боломжгүй байж болно. Энэ нь тэрээр анхнаасаа холбогдох мэдээлэлгүй байсан эсвэл дэлгэрэнгүй мэдээллийг бичиж чадаагүйтэй холбоотой байж болох юм. Цаг хугацаа өнгөрч, ярилцагчдад тохиолдсон үйл явдлууд нь анхны нарийн ширийн зүйлийг мартахад хүргэсэн эсвэл санах ойгоос сэргээхэд саад болсон байж магадгүй юм.
124. Ярилцлага авагчид нь ярилцлага өгч байгаа хүн ярихаас татгалзаж болох асуудалд хүндэтгэлтэй хандаж, түүний өгсөн аливаа мэдээллийг хуулиар зөвшөөрөгдсөн хязгаарт багтаан нууцлахыг мэдэгдэж, үргэлжлүүлэн ярихаас татгалзсан тохиолдолд хүндэтгэлтэй хандах нь ярилцлага үр дүнтэй байх магадлалыг нэмэгдүүлнэ. Ярилцлага өгөгч асуултад хариулахаас татгалзсан эсвэл бүтэлгүйтсэнээс үүдэн сөрөг дүгнэлт гаргах ёсгүй бөгөөд гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн зөвшөөрсөн, эсвэл ичгүүртэй байх мэдээлэл өгөх тохиолдолд ярилцлага авагч нь шүүмжлэлтэй хандах ёсгүй.

Ярилцлагыг түр зогсоох

125. Ярилцлага авагчид олж авсан мэдээллийн мөрөөр болон нэмэлт асуулга явуулахын тулд ярилцлагыг түр зогсоох нь зүйтэй бөгөөд энэ нь хүлээн зөвшөөрөгдөхүйц юм. Үүний нэгэн адил, өмгөөлөгч эсвэл ярилцлага өгөгч нь амрах эсвэл ганцаарчлан зөвлөлдөх зорилгоор завсарлага авах хүсэлт гаргаж болно. Ийм хүсэлтийг хүлээн авахаас татгалзах нь ярилцлагаас олж авсан мэдээллийн найдвартай байдалд нөлөөлж болзошгүй.
126. Ярилцлага өгөгч эмнэлгийн тусламж авах шаардлагатай бол ярилцлага авагч ярилцлагыг нэн даруй түр зогсоож, цаг алдалгүй тусламж үзүүлэх ёстой.
127. Сэжигтнээс мэдүүлэг авахад тавигддаг хуулийн шаардлагаас зайлсхийх зорилгоор хүмүүсээс гэрчийн мэдүүлэг авахгүй байх нь чухал. Ярилцлагын явцад анх гэрчээр ярилцлага өгсөн хүн сэжигтэн болсон тохиолдолд ярилцлага авагч нь түүний статус сэжигтнийх болж өөрчлөгдсөн тухай мэдэгдэхийн тулд ярилцлагын явцыг нэн даруй зогсооно. Ярилцлага авагч нь сэжигтний эдлэх эрхийн талаар ярилцлага өгөгчид мэдэгдэж, уг эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай цаг хугацаа, боломжоор хангах ёстой.



Ярилцлагыг дуусгах - Үнэлгээ ба дүн шинжилгээ

128. Үр дүнтэй ярилцлага авагч ярилцлагаа үргэлж хүндэтгэлтэй, мэргэжлийн байдлаар дуусгах ёстой. Энэ нь цаашдын харилцаа холбооны сувгуудыг нээлттэй байлгах магадлалыг нэмэгдүүлж, болзошгүй үл ойлголцлоос зайлсхийж, төрийн байгууллагуудад итгэх итгэлийг нэмэгдүүлдэг.
129. Ярилцлага авагч нь ярилцлага өгөгчөөс олж авсан мэдээллийг (өмгөөлөгч оролцсон бол түүнд мөн адил), бичмэл бичлэг (аудио/видео бичлэгээс ялгаатай) хийгдсэн бол бичлэгийн үнэн зөвийг баталгаажуулж, гарын үсэг зурах хүсэлт тавих хэрэгтэй. Аливаа нэмэлт өөрчлөлт, тухайлбал ярилцлага өгч буй этгээд гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдол зэргийг бүгдийг тэмдэглэж авна. Бичсэн тэмдэглэлийн хуулбарыг ярилцлага өгөгч болон түүний өмгөөлөгчид (хэрэв оролцсон бол) өгнө. Улмаар ярилцлага авагч ярилцлага өгөгчид үйл явцын дараагийн үе шатуудын талаар зохих мэдээллийг өгөх ёстой.
130. Ярилцлага дууссаны дараа ярилцлага авагч нь энэ ажиллагааны явцад өгсөн мэдээлэл нь хувийн нууцлал, мэдээллийн хамгаалалтын зохих түвшнийг хангаж байгаа эсэхийг баталгаажуулна. Тухайлбал, олж авсан мэдээллийг ярилцлага өгөгчийн эрхийг эрсдэлд оруулахуйц байдлаар олон нийтэд эсвэл байгууллагад, бусдад мэдэгдэхгүй байхыг баталгаажуулах зэрэг багтаж болно.
131. Үнэлгээ, дүн шинжилгээ нь амжилттай ярилцлагын үйл явцын салшгүй хэсэг юм. Үүнд зарцуулсан цаг хугацаа нь асуудлын ноцтой байдлаас хамаарч өөр өөр байж болох хэдий ч, хэзээ ч бүү яар. Ярилцлага авагч дараах зүйлийг үнэлж, дүн шинжилгээ хийх ёстой.
- a. Олж авсан мэдээллийн үнэ цэнэ, найдвартай байдал, энэ нь мэдэгдэж буй нотлох баримт, мэдээллийн цоорхой болон бусад цуглуулсан тагнуулын мэдээлэлтэй хэрхэн нийцэж байгаа эсэх.
 - b. Мөрдөн шалгах ажиллагааг урагшлуулахын тулд ямар нэмэлт лавлагаа эсвэл үйл ажиллагаа шаардлагатай эсэх.
 - c. Холбогдох бүх хамгаалалтын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх.

ГУРАВДУГААР ЗАРЧИМ ЭМЗЭГ БАЙДАЛ

Үр дүнтэй ярилцлага хийх нь эмзэг нөхцөл байдалд ярилцлага өгөгчдийн хэрэгцээг тодорхойлж, шийдвэрлэхийг шаарддаг.



Ярилцлага эмзэг байдлын нөхцөл байдал дээр тулгуурлах нь

132. Бараг бүх ярилцлага өгөгчид эрх бүхий этгээдтэй харилцах харилцааны хүчний тэнцвэргүй байдлаас болж эмзэг байдалд ордог. Ялангуяа ярилцлага өгөгчийг баривчлан саатуулснаар эдлэх эрх нь эрх баригчдаас бүрэн хамааралтай болох үед эрх мэдлийн тэнцвэргүй байдал хурцаддаг.
133. Ярилцлага авагчид эрх мэдлийн тэнцвэргүй байдлын болзошгүй үр дагаврыг мэдэж, түүнийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд ингэснээр ярилцлагад хамрагдсан бүх хүнийг хуулийн дагуу хамгаалж, цуглуулсан мэдээллийн үнэ цэнийг нэмэгдүүлэх болно. Иймэрхүү хариу үйлдэл нь тухайн хүний бие махбод, танин мэдэхүйн болон сэтгэл хөдлөлийн хариу үйлдэлд нөлөөлж, тавьсан асуултууд болон түүнд өгөх хариултын үр дагаврыг ойлгоход саад учруулж болзошгүй. Эдгээр нь ярилцлага өгөгчийн өөрсдийн ашиг сонирхлын үүднээс шийдвэр гаргах эсвэл нарийвчилсан, үнэн зөв мэдээлэл өгөх чадварт нөлөөлж болно. Тэр ч бүү хэл, зарим ярилцлагад хамрагдагсад стрессийн байдлаасаа үүдэн сэргээн санах чадвар нь буурч, худал мэдээлэл өгөхөд ч хүргэж болзошгүй.
134. Эдгээр зарчмыг дагах мөрдөх нь ярилцлагад оролцогчдыг тайвшруулж, албадлагагүй орчин бүрдүүлэхэд тустай ба ихэнх зарчим нь ярилцлага авагч эрх мэдлээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ингэснээр зүй бус харьцаа өрнөх ихээхэн эрсдэлтэй "албан бус" ярилцлага явагдахаас ч урьдчилан сэргийлдэг.



Хурц эмзэг нөхцөл байдалд байгаа хүмүүс

135. Ярилцлага нь бусад эрсдэлт хүчин зүйлүүдтэй огтлолцох тохиолдолд ярилцлагад хамрагдагсдын зарим нь эмзэг байдалд өртсөнөө мэдэрдэг. Ийм тохиолдолд эрх бүхий байгууллагаас анхаарал хандуулах шаардлагатай нэмэлт хэрэгцээ, эрх урган гардаг. Дараах эрсдэлт хүчин зүйлс байж болно, тухайлбал:
 - a. Нас, хүйс, жендер, хүйсийн баримжаа эсвэл хүйсийн илэрхийлэл, бэлгийн чиг баримжаа
 - b. Үндэс, угсаа гарал
 - c. Соёлын эсвэл шашны гарал
 - d. Бие махбодын, оюуны болон сэтгэцийн бэрхшээл
 - e. Харилцааны хүндрэлүүд
 - f. Ойлгоход бэрхшээлтэй байх (хэлний бэрхшээл гэх мэт)
 - g. Унших, бичих чадваргүй байх
 - h. Дементиа зэрэг насжилттай холбоотой өвчин
 - i. Цөөнхийн бүлэг эсвэл нийгэм-эдийн засгийн гадуурхагдсан бүлэг.
136. "Эмзэг байдал" нь үргэлж хувьсан өөрчлөгддөг ойлголт тул эмзэг байдлыг нэмэгдүүлж болзошгүй нөхцөл байдлын бусад шинж чанаруудыг дараах байдлаар тодорхойлж болно:
 - a. Осол гэмтэл, өвчин эмгэг, сэтгэцийн хямрал, түгшүүр, архины хордлого, гэмтлийн дараах стрессийн эмгэг, бусад доройтсон эсвэл өөрчлөгдсөн байдал зэрэг эрүүл мэндийн байдал.
 - b. Хүчирхийлэл, хүний эрхийн зөрчилд өртөж байсан, эсвэл гэрч болсон зэрэг өмнөх тохиолдлоос үүдэлтэй гэмтэл.
 - c. Цагаачлалын статус, тухайлбал орогнол хүсэгч эсвэл дүрвэгч, хүлээн зөвшөөрөгдөөгүй цагаач, хууль бус цагаач ажилтан, бичиг баримтгүй цагаач, хүний наймааны хохирогч.
 - d. Жирэмсэн эсвэл хөхүүл байх, эсвэл үндсэн асран хамгаалагч байх, асрамжийн өөр зохицуулалт хийх боломжийг олгоогүй байдалд байх.
 - e. Бага насны хүүхэд хүчирхийлэгч, улс төрийн гэмт хэрэгтэн, террорист ажиллагаа зэрэг гэмт хэрэгт шалгагдаж байгаа этгээдүүд.
137. Эрсдэл нь нөхцөл байдал, соёл, цаг хугацаа зэрэг хүчин зүйлээс хамаарч хэлбэлзэж болно. Эмзэг байдлыг нэмэгдүүлсэн шинж чанарууд нь байнгын эсвэл түр зуурын шинж чанартай байж болно. Зарим тохиолдолд хүний маш эмзэг байдал илэрхий эсвэл аль хэдийн баримтжуулсан байж болно; бусад тохиолдолд энэ нь мэдэгдэхгүй эсвэл шууд харагдахгүй байж болно.



Үүний нэгэн адил энэ нь амьдралын өвөрмөц бодит байдал, туршлагыг бий болгож, ялгаварлан гадуурхах, зүй бусаар харьцах эмзэг байдлыг бий болгодог хэд хэдэн огтлолцсон хүчин зүйлийн үр дүн байж болно.

138. Насны хувьд хүүхдүүд үргэлж эмзэг байдалд ордог бөгөөд ярилцлагын үеэр тэдний зохих хамгаалалтыг хангах тусгай арга хэмжээ авах шаардлагатай болдог. Иймээс тусгай сургалтад хамрагдсан ярилцлага авагч л хүүхэдтэй ярилцлага хийх нь тохиромжтой байдаг. Хүүхэдтэй хэрхэн хамгийн сайн харилцах, харилцаа холбоо тогтоох, ярилцлагыг хаана, хэзээ хийх талаар анхаарч үзэх хэрэгтэй. Хохирогч, гэрч хүүхдүүд тусгай сургалтад хамрагдсан ярилцлага авагчидтай ярилцлагад орох ёстой.
139. Хүүхдийг гэмт хэрэгт сэжиглэж байгаа үед тэднээс мэдүүлэг авах, мөн гэмт хэрэгтэй холбоотой аливаа мэдэгдэл, баримт бичигт өмгөөлөгч, итгэмжлэгдсэн насанд хүрсэн хүний оролцоогүйгээр гарын үсэг зуруулахыг хэзээ ч зөвшөөрч болохгүй.
140. Ярилцлага авагчид тодорхой зан үйл нь хувь хүний эмзэг байдлыг нэмэгдүүлж болзошгүйг ойлгож, энэ нь ярилцлага өгч буй хүний хариултуудад нөлөөлөхгүй байхад анхаарч ажиллах хэрэгтэй. Үүнд эдгээр зүйлс багтана:
 - a. Ярилцлагад оролцогчид, ялангуяа хүүхэд болон ярилцлагад хамрагдсан сэтгэц-нийгмийн болон оюуны хомсдолтой, амархан өдөөгдөж, хурц үйлдэл гаргаж болзошгүй этгээдээс удирдан чиглүүлсэн, төөрөгдүүлсэн асуулт асуух, эсвэл мэдүүлэг авах үеийн дарамт шахалт, арга заль хэрэглэх нь найдваргүй мэдээлэл хүлээн авах шалтгаан болдог.
 - b. Ярилцлагыг аль болох хурдан дуусгахын тулд ямар ч бодолгүйгээр эерэг хариулт өгөх хандлага.
 - c. Зүй бусаар харьцах эсвэл санал нийлэхгүй байх айдсаасаа болж ярилцлага өгч буй этгээд ярилцлага авагчийн сонсмоор байгаа хариултыг нь өгөх.
141. Байгууллагын өрөөсгөл байдал, ялгаварлах үзэл, ойлголт, сургалт дутаг, зохих дэд бүтэц муу зэргээс шалтгаалан тухайн этгээд маш эмзэг байдалд орох магадлалтай. Эдгээр дутагдал нь байгууллагын бүтэц, бодлого болон/эсвэл хувь хүний дүгнэлт, үйл ажиллагаанд нөлөөлж болно.

Өсөн нэмэгдэж буй эмзэг байдлын нөхцөл байдлыг үнэлэх, шийдвэрлэх

142. Эрх бүхий байгууллага нь маш эмзэг байдалд байгаа хүний онцлог хэрэгцээ, эрхийг хангах, ялангуяа ялгаварлан гадуурхахгүй байх, өөрийнхөө эсрэг албадан мэдүүлэг өгөхөөс хамгаалах талаар сайжруулсан хамгаалалт,



тусгай арга хэмжээ хэрэгжүүлэх ёстой. Энэ нь хууль эрх зүйн болон процедурын ялгаатай хамгаалалтуудын хэрэглээг шаардаж болох юм.

143. Эрх бүхий байгууллага нь ярилцлага хийхээс өмнө тухайн хүн эмзэг байдалд байгаа эсэх, түүнд онцгой анхаарал хандуулах шаардлагатай эсэхийг үнэлэх ёстой. Авах арга хэмжээ нь уян хатан, тохирсон байх шаардлагатай. Ярилцлага авагчид болон бусад холбогдох байгууллагууд эсрэг хүйсийн эсвэл тусгайлан бэлтгэгдсэн гэх зэрэг өөр ярилцлага авах этгээдийг дуудах эсвэл тодорхой мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх эсэхээ тохиолдол тус бүрээр авч үзэж, тодорхойлох ёстой. Зарим алхмуудыг хуульд заасан байх ёстой ба заримыг ярилцлага авагчийн дүгнэлтэд тулгуурлана.
144. Ярилцлага өгөгчийн хэрэгцээг үнэлж, шийдвэрлэхдээ тухайн үйл явдлын талаарх асуулт, хэлэлцүүлгийг хамгийн бага хэмжээнд байлгах хэрэгтэй. Энэ нь албан ёсны асуулт асуухаас өмнө ярилцлага авагчийн ой санамжийг өөрчлөх, булингартуулах эрсдэлээс зайлсхийхэд тусална.
145. Эмзэг байдал нь ярилцлага авагчийг найдвартай мэдээлэл өгөхөд заавал саад учруулахгүй байж болно; энэ нь ихэвчлэн бусад дэмжлэгтэйгээр хийгдэх бүрэн боломжтой байдаг. Жишээлбэл, ярилцлагад оролцогчид сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй тулгарвал мэргэжлийн орчуулагч эсвэл өөр тусламж шаардлагатай байж болно. Ярилцлага өгч буй этгээдийг сайн мэддэг, тухайлбал гэр бүлийн хүнтэй зөвлөлдөх, эсвэл нийгмийн ажилтан нь ярилцлага өгч буй этгээдтэй харилцах харилцааг хөнгөвчлөх боломжтой.
146. Эмзэг байдлын үнэлгээний бүрэн бүтэн бүртгэл, алхмуудыг хийснээр ярилцлага авагч нь ярилцлага өгч буй этгээдийг дэмжих чухал хамгаалалт болдог. Ийм бичиг баримт нь үр дүнтэй харилцаа холбоо, оролцоог идэвхжүүлж, шаардлагатай алхмуудыг тодорхойлж, мэдээлэл цуглуулах үйл явц болон ярилцлага өгөгчийн аюулгүй байдлыг хангахад тусалдаг. Сэжигтний тухайд ярилцлага авагч нь илрүүлсэн аливаа эмзэг байдлынх нь талаар ярилцлага өгөгчийн хууль ёсны төлөөлөгчдөд мэдэгдэх ёстой бөгөөд ярилцлага өгч буй этгээдийн хэрэгцээг хангахын тулд хийсэн арга хэмжээний талаар мэдээлэх ёстой.
147. Эмзэг байдал нь ихэссэн нөхцөлд ярилцлага өгөгчтэй ярилцах этгээд нь боломжтой бол тусгай сургалтад хамрагдсан эсвэл зохих шинжээчийн туслалцаа авсан байх ёстой. Хүүхдүүдийн хувьд ярилцлагын үйл явц нь тусгай журмын дагуу явагдах бөгөөд тусгайлан бэлтгэгдсэн ярилцлага авагч ярилцах ёстой.
148. Ярилцлага авагч нь ярилцлага хийж буй байршил, орчин нь эмзэг байдлын өндөр түвшинд байгаа ярилцлага өгөгчийн хувьд хүндрэл учруулахгүй байх үүднээс боломжийн арга хэмжээ авах ёстой.

ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ СУРГАЛТ

Үр дүнтэй ярилцлага хийх нь тусгай сургалт шаарддаг мэргэжлийн ажил юм.



149. Ярилцлага хийж буй бүх ажилтнууд, түүний дотор цагдаа, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, тагнуул, цэргийн албан хаагчид энэхүү баримт бичигт заасан зарчмын дагуу үр дүнтэй ярилцлага хийх тусгай сургалтад хамрагдах ёстой. Ингэснээр олон улсын болон үндэсний хууль тогтоомж, байгууллагын дүрэм, мэргэжлийн өндөр стандартад нийцүүлэн ярилцлагыг ойлгох, бэлтгэх, явуулах боломжийг олгоно.
150. Ярилцлагад хамрагдагч бүх төрлийн бүлгээс үнэн зөв, найдвартай мэдээлэл цуглуулахад чиглэгдсэн бодлого, практикт чиглэсэн институтийн өөрчлөлтийг дэмжих үүднээс үр дүнтэй ярилцлагын арга техникийг бүх байгууллагад сурталчлах хэрэгтэй.
151. Мэргэжлийн өндөр стандарт тогтоох нь сонгон шалгаруулалтын хатуу шалгуурт тулгуурласан өрсөлдөөнт шалгаруулалтын дүнд ярилцлага хийх чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийн олон талт байдлыг бүрдүүлэх явцыг дэмждэг.

Тусгай сургалт

152. Тусгай сургалт нь ярилцлага авагчид ярилцлагад хэрхэн бэлдэж, түүнийг хэрхэн зохион байгуулахад тогтвортой байдлыг хангах болно. Ярилцлагын аргууд нь үнэн зөв, найдвартай мэдээлэл олж авахад тусалж, худал мэдээлэл олж авах эрсдэлийг бууруулдгийг баталсан холбогдох судалгаанд тулгуурласан практик арга зүйг сургалтаар заах ёстой.
153. Үр дүнтэй ярилцлагын сургалтын агуулга нь мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах өргөн хүрээний үйл явцын чухал хэсэг нь ярилцлага бөгөөд энэ нь эцсийн дүндээ шүүхийн харьяаллаас үл хамааран шударга ёсны үйл явцын чухал бүрэлдэхүүн хэсэг мөн болох тухай агуулгыг багтаах ёстой.



Ярилцлагын үр дүн, холбогдох хамгаалалтыг онцлох нь хүний эрхийг хангах талаар төрөөс хүлээсэн үүргийг биелүүлэх, эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахаас урьдчилан сэргийлэх гол түлхүүр юм.

154. Үр дүнтэй ярилцлагын сургалтын гол элементүүд нь дараах зүйлийг агуулдаг:
- a. Нээлттэй сэтгэлгээтэй байж, өрөөсгөл ойлголтоос зайлсхийх
 - b. Стратегийн хувьд төлөвлөж, бэлтгэх
 - c. Харилцаа холбоог бий болгож, сайн хадгалах
 - d. Ярилцлагад оролцогчдын тусгай хэрэгцээг тодорхойлж, түүнд хариу өгөх
 - e. Олон улсын хүний эрхийн хуулийг дагаж мөрдөх
 - f. Ярилцлагын явцад хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэхийг шалгах
 - g. Шинжлэх ухааны үндэслэлтэй асуулт асуух арга техникийг ашиглах
 - h. Идэвхтэй сонсох чадварыг ашиглаж, ярилцлага авагчид асуултад бүрэн хариулах боломжийг олгох
 - i. Ярих дургүй байгаа ярилцагчтай харилцах
 - j. Ярилцлага өгөгчийн өмгөөлөгчтэй харилцах
 - k. Ярилцлагыг мэргэжлийн түвшинд эхлүүлж, дуусгах
 - l. Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх
 - m. Ур чадвараа дээшлүүлэх үүднээс ярилцлагын үйл явцыг үнэлэх.
155. Ярилцлагад бэлтгэх сургалт нь шаардлагатай онолын үндэс, практик мэдлэг олгоход хангалттай урт байх ёстой бөгөөд удирдлага болон хамт ажиллагсдынхаа санал хүсэлтийг харгалзан бодит ажлын хувилбаруудыг ашиглан хэд хэдэн практик хичээлийг багтаасан байх ёстой.
156. Өмнө нь ярилцлага авч байсан хүмүүс болон бусад мэргэжилтнүүдийн оролцоо (эмнэлгийн боловсон хүчин, хэлмэрч, туслах хүмүүс) дүрд суурилсан хичээлээр сургалтын туршлагыг баяжуулж болно.
157. Хүүхэд, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс гэх мэт эмзэг нөхцөлд байгаа хүмүүстэй ярилцлага хийхэд оролцох ярилцагч, зуучлагч, хэлмэрч нарыг нэмэлт сургалтад хамруулах шаардлагатай. Ийм сургалтад ярилцлага өгөгчийн сэтгэл зүйн байдлыг хэрхэн хянах, шаардлагатай бол ярилцлагыг хэрхэн зогсоох, зохих ёсоор бэлтгэгдсэн мэргэжилтнүүдээс тусламж авах талаар зааварчилгааг агуулсан байх ёстой.
158. Ярилцлага авагчдыг удирдаж, хянадаг албан тушаалтан ч гэсэн сургалтад хамрагдах ёстой бөгөөд зөвхөн ярилцлага хийх ур чадвараа сайжруулахаас

гадна ерөнхий чанарыг хэрхэн үнэлэх, ярилцлага авагчдад зохих санал хүсэлт, дэмжлэг үзүүлэх зорилгоор ярилцлага хийх талаар суралцах хэрэгтэй.

159. Шүүгч, прокурор, цагдан хорих байгууллагын ажилтан, өмгөөлөгч зэрэг холбогдох хүмүүст үр дүнтэй ярилцлагын талаар мэдээлэл өгөх шаардлагатай. Энэ нь тус тусын үүрэг, тулгамдсан асуудлын талаар нийтлэг ойлголтыг бий болгож, гомдол гарвал хөндлөнгийн хяналт, үнэлгээ хийхэд тусалдаг.
160. Сургалтад техник, технологи ашиглах нь цаашдын судалгаанд үнэ цэнтэй мэдээлэл бий болгох, ярилцлагын чанарыг сайжруулахад тусална. Тухайлбал, дуу дүрсний төхөөрөмж ашиглан сургалтын бичлэг хийх, цахимаар ярилцлага хийж, дүрд суурилсан хичээл явуулах зэрэг арга байж болно.
161. Хууль сахиулах байгууллага, цэрэг, тагнуулын алба хаагчид, хяналтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын түншүүдийн сургалтын хамтын ажиллагааг дэмжих ёстой. Эрдэм шинжилгээний бие даасан судлаачид холбогдох судалгаагаа олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй болгоход дэмжлэг үзүүлэх ёстой.
162. Сургалтын хөтөлбөрүүдийг олон улсын хүний эрхийн стандарт, шинжлэх ухааны судалгааны хөгжлийн өөрчлөлтийг тусган тогтмол шинэчилдэг байх ёстой. Тогтмол өөрчлөн шинэчлэгдэх судалгаа, практикт батлагдсан арга техникууд нь сургалтын хөтөлбөрийг бэхжүүлнэ.

Мэргэжлийн тасралтгүй хөгжил

163. Ярилцлага хийх мэдлэг, ур чадвараа цаг хугацааны явцад хадгалах шаардлагатай. Тасралтгүй мэргэжил дээшлүүлэх хөгжлийн хөтөлбөрүүдэд үр дүнтэй ярилцлага хийх хичээлийг оруулах нь зүй ёсны ба, тухайн байгууллага үр дүнтэй ярилцлага хийх талаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд тусална.
164. Тасралтгүй мэргэжил дээшлүүлэх хөгжлийн хөтөлбөрүүдэд тууштай манлайлал, тогтмол сургалтын бататгах, техникийг боловсронгуй болгох, алдааг засах давтан сургалт, хамгийн сүүлийн судалгааг танилцуулах зэрэг үйл ажиллагаа багтана.
165. Тасралтгүй мэргэжил дээшлүүлэх хөгжлийн хөтөлбөрүүд нь байгууллага, ялангуяа удирдлагуудад ярилцлагын гүйцэтгэлийг илүү сайн хянаж, дүгнэх, цаашдын сургалтын хэрэгцээг тодорхойлох, хөгжиж буй технологийн хэрэглээг сайжруулах, судалгааны мэдлэгийг шинэчлэх боломжийг олгох ёстой.





ТАВДУГААР ЗАРЧИМ ХАРИУЦЛАГА

Үр дүнтэй ярилцлага хийхэд инсититууд ил тод, хариуцлагатай байх ёстой.



166. Үйл ажиллагааны стандарт журам, ёс зүйн дүрэм эсвэл эрх бүхий байгууллагын бусад удирдамж нь ярилцлагын үр дүнтэй практикт хувь нэмэр оруулж, байгууллагын соёлыг өөрчлөхөд түлхэц болдог.
167. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 11 дүгээр зүйлд заасны дагуу эрх баригчид ярилцлага хийхтэй холбоотой одоо мөрдөж буй дүрэм, заавар, арга, туршлагыг системтэй, нарийн, өргөн хүрээнд хянадаг байх ёстой. Энэхүү үнэлгээнд үндэслэн мөрдөн шалгах байгууллагын ярилцлага хийж буй төлөөлөгчид мөрдөж болохуйц стандартыг тогтоохын тулд үйл ажиллагааны стандарт журам, бодлого, ёс зүйн дүрмийг баталж, гаргах ёстой. Ийм хэм хэмжээ нь хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон ярилцлага хийх үүрэгтэй бусад албан тушаалтнуудын зан үйлийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцсэн байх ёстой.
168. Эрх баригчдын тогтмол хяналт шалгалт нь технологийн зохистой хэрэглээ зэрэг ярилцлагад оруулсан санхүүгийн эх үүсвэрийн түвшнийг үнэлэх ёстой. Тогтмол хяналт шалгалт хийснээр үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг дагаж мөрдөх байдал хангагдах ба түүнийг сайжруулахын тулд үечлэн хийх хэрэгтэй.
169. Хяналтыг явуулахдаа бие даасан судлаачид, үр дүнтэй ярилцлага хийх туршлагатай мэргэжилтэн, байгууллагуудын мэдлэг, тусламжид тулгуурлан явуулна.
170. Ил тод, хариуцлагатай байдлыг төрийн бүх түвшинд, тэр дундаа хувь хүн, хяналт, зохион байгуулалтын түвшинд хэрэгжүүлэх ёстой.

171. Ил тод байдал нь байгууллагын шударга байдал, шударга ёсны ерөнхий удирдлагад итгэх олон нийтийн итгэлийг хадгалахад маш чухал юм. Эрх баригчид ярилцлага хийхтэй холбоотой дотоод дүрэм, журмыг танилцуулах ёстой.
172. Ярилцлагад оролцогчид, тэдний гэр бүл, өмгөөлөгчид нь үзүүлж буй хуулийн үйлчилгээ болон хяналтын механизмын талаарх мэдээлэл авах эрхийг баталгаажуулах ёстой.
173. Ярилцлагын явцад цуглуулсан бүх хувийн мэдээллийг нууцлал, хувийн нууцыг хадгалах, зохисгүй ашиглахгүй байх, мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн дагуу хамгаалах ёстой.

Үр дүнтэй бүртгэл хөтлөх

174. Мэдээллийг үр дүнтэй бүртгэх нь ил тод, хариуцлагатай байх урьдчилсан нөхцөл юм. Сайн бүртгэл хөтлөх нь эрсдэлийг эрт илрүүлэх, нөөцийн хуваарилалт, хяналт шалгалтын үйл явц, судалгаа зэргийн гүйцэтгэлийг төлөвлөхөд ач холбогдолтой.
175. Хэн нэгнийг цагдан хорих бүрд цагдан хорьсон тухай бүртгэлийг цахим хэлбэрээр аль болох хурдан нээх ёстой.
176. Бүх ярилцлагыг үнэн зөв бүртгэх ёстой бөгөөд дуу дүрсний технологийг ашиглах нь зохистой. Хэдийгээр дуу дүрсний бичлэгийг аажмаар хэрэгжүүлэх шаардлагатай байдаг ч үүнийг ашигласнаар найдвартай, бодит үр ашиг, хэмнэлт гарч ирдэг.
177. Дуу дүрсний бичлэг нь ярилцлагын үеэр зүй бусаар харьцсан тухай аливаа мэдэгдлийг шалгахад дөхөм болно. Энэ нь зүй бусаар харьцсан гэж мэдэгдэж байгаа хүмүүс болон зүй бус харьцсан гэх мэдээлэлд холбогдсон ярилцлага авагчдын ашиг сонирхолд нийцнэ.

Урьдчилан сэргийлэх, мэдээлэх

178. Үр дүнтэй ярилцлага хийх, холбогдох хамгаалалтыг хүндэтгэх амлалтыг холбогдох байгууллагуудын дотоод дүрэм, ёс зүйн дүрэм, гүйцэтгэлийн үнэлгээнд тусгах ёстой.
179. Ярилцлага явуулж буй бүх агентлагууд аливаа зөрчлийг илрүүлэх, зөрчлийг засаж залруулах, сахилга батжуулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах тодорхой журам бүхий дотоод хяналтын тодорхой хэлхээтэй, шударга бус байдлыг мэдээлдэг, хэлмэгдүүлэлтээс хамгаалсан, өөрөө өөрийгөө зохицуулдаг дотоод гомдол, мөрдөн шалгах албатай байх ёстой.



180. Ярилцлагын дотоод журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд давтан сургахаас эхлээд сахилгын арга хэмжээ авах хүртэл зохих хариу арга хэмжээ авах ёстой. Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцахыг туйлын хориглох зэрэг хуулийн үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээлгэх ёстой. Аливаа сахилга бат, сайн зан үйлийн зөрчлийг олон улсын хууль тогтоомж, процедурын шударга ёсны стандартын дагуу шударга, пропорциональ байдлаар шийдвэрлэх ёстой.
181. Төрийн албан тушаалтнууд нь тухайн хүний зэрэг дэвээс үл хамааран, хаана ч, ямар ч нөхцөлд хууль бус үйлдлийг хэзээ ч үл тоомсорлож болохгүй.
182. Удирдлага нь хэн нэгний мэргэжлийн бус зан үйл, буруу үйлдлийн талаар зохих ёсоор мэдээлэх бөгөөд үнэлэлт дүгнэлт өгөх, зэрэг арга хэмжээ авах, тайлагнах эсвэл өөр бусад арга хэмжээ авах ёстой.
183. Эрүүдэн шүүх, зүй бусаар харьцсан талаар мэдээлэх үүрэгтэй байх ёстой бөгөөд үүнийг хамгаалах ёстой. Хэрэв албан тушаалтан хамтажиллагсдаасаа шууд асууж, шаардаж чадахгүй гэж үзвэл салбарын менежер, агентлагийн мэдээлэх механизм эсвэл хяналтын механизмыг багтаасан бусад зохих сувгаар дамжуулан асуудлыг мэдээлэх ёстой. Тэдний санаа зовоосон асуудалд зохих хариу өгөөгүй мэт сэтгэгдэл төрүүлсэн тохиолдолд ч энэхүү үүрэг нь мөн адил хамаарна.
184. "Шүгэлүлээгч" гэх мэт зөрчлийн талаар мэдээлсэн хүн аливаа хэлмэгдүүлэлт, сөрөг хандлагаас зохих хамгаалалтаар хангагдах ёстой.
185. Ярилцлага авахтай холбоотой буруутай үйлдлийг харсан, сонссон, сэжиглэж буй өмгөөлөгч, прокурор, шүүгч зэрэг эрүүгийн эрх зүйн бусад мэргэжлийн хүмүүс мөн энэ мэдээллийг холбогдох сувгаар агентлагийн анхааралд хүргэх эсвэл холбогдох бусад байгууллагад мэдээлэх үүрэгтэй.
186. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх, ярилцлага хийх арга барилыг сайжруулахад эрүүгийн эрх зүйн мэргэжилтнүүд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, ялангуяа эрүүдэн шүүх, бусад хэлбэрээр зүй бус харьцах, процессын зөрчил, албадлагын аливаа хэлбэрээр олж авсан нотлох баримтыг шүүх хуралдаанаас хасах үүрэг багтана.
187. Шүүх хуралдаанд хэргээ хүлээсэн мэдүүлэгт хэт найдах нь "ярилцлагын цорын ганц зорилго бол хэрэг хүлээлгэх явдал" гэж үзэх зохисгүй хөшүүргийг бий болгодог тул ярилцлага авагч нь үүнээс зайлсхийх хэрэгтэй.

Хөндлөнгийн хяналт, хараат бус хяналт

188. Хүний эрхийн үндэсний байгууллагууд, Омбудсмены газар, шүүхийн байгууллага эсвэл мэргэжлийн хяналтын байгууллага зэрэг хөндлөнгийн



- хяналтын байгууллагууд аливаа байгууламжид нэвтрэх, цагдан хоригдож буй хүнтэй ярилцлага хийх, хоригдож буй хүмүүсийн талаарх мэдээлэл авах боломжтой байх ёстой.
189. Хөндлөнгийн хяналтын байгууллага нь хорих ангид аливаа хүнтэй нууцаар харилцах боломжтой байх ёстой. Төрийн албан хаагч зүй бус харьцсан зөрчлийн талаар гомдол гаргаж байгаа хүмүүс нь хараат бус хянагч байгууллагуудтай бүрэн нууцлалтайгаар харилцах эрхтэй байх бөгөөд ингэхдээ хэлмэгдүүлэлтээс айхгүйгээр, боломжийн нөхцөлөөр аюулгүй байдал, сайн дэг журам нь хангагдсан байх ёстой.
190. Хүний эрхийн үндэсний байгууллагуудын тухай Парисын зарчмын дагуу хөндлөнгийн хяналтын байгууллага нь хүмүүстэй ярилцлага хийж байгаа газрын үйл ажиллагаанд нарийвчилсан, шуурхай, шударга дүн шинжилгээ хийх, хүний эрх, нэр төрийг хүндэтгэх байдлыг хангах үүднээс хараат бус, хангалттай нөөц бололцоотой байх ёстой.
191. НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын Нэмэлт протоколд Оролцогч улсууд урьдчилан сэргийлэх үндэсний механизмд цагдан хорих газруудад гэнэтийн айлчлал хийх эрхийг олгох ёстой. Тэд мэдээлэл, бүртгэлд хандахаас гадна эрх чөлөөгөө хасуулсан хүмүүс болон ажилтнуудтай ганцаарчлан ярилцлага хийх эрхтэй байх ёстой.
192. Улс орнууд ярилцлагын үр нөлөөг сайжруулах, хууль эрх зүйн хамгаалалтыг сайжруулахад шаардлагатай аливаа шинэчлэлийн талаар зөвлөмж гаргах боломжийг хөндлөнгийн хяналтын байгууллагуудад олгох тогтолцоо, үйл явцыг бий болгох ёстой. Эрх баригчид өөрсдийн дүгнэлт, зөвлөмжийн дагуу гаднын байгууллагуудтай яриа хэлэлцээ хийх үүрэг хүлээх ёстой.
193. Иргэний нийгмийн байгууллагууд ч гэсэн бие даасан хяналт, мониторинг хийхэд гол үүрэг гүйцэтгэж чадна. Эрх баригчид тэдний оролцоог сайшааж, цагдан хорих газруудад хяналт тавьж, ярилцлага хийсний үр дүнд гаргасан аливаа тайланг зохих ёсоор анхаарч үзэх ёстой; Үүнд гэрч, хохирогчтой хийсэн ярилцлага орно.

Гомдол гаргах, мөрдөн шалгах

194. Ярилцлагад хамрагдсан бүх хүмүүс эрхээ эдэлж чадаагүй зэрэг аливаа зүй бус харьцсан талаар гомдол гаргаж, хамгаалуулах эрхтэй. Ийм гомдлыг нэн даруй эрх бүхий сувгаар дамжуулан бүрэн гүйцэд, шударга шалгах ёстой.
195. Гомдолд хандах механизм нь хялбар, шууд, үнэ төлбөргүй, нууц байх ёстой. Гомдлын механизмыг хангахын тулд зохих арга хэмжээг бүх хүнд, ялангуяа эмзэг байдлын өндөр түвшинд байгаа хүмүүст хүртээмжтэй байхаар авах ёстой. Гомдол гаргагчид гомдлын үйл явц, давж заалдах механизмын талаар тодорхой зааварчилгаа авах ёстой.

196. Бүх гомдлыг хэзээ гарснаас үл хамааран бүртгэх ёстой. Ийм гомдол нь албан ёсны бүртгэлд орсон байх ёстой. Ярилцлагын явцад ярилцлага өгөгчөөс эсвэл түүний өмнөөс гомдол гаргасан тохиолдолд ярилцлага, хийж буй бичлэгийг түр зогсоох ёстой.
197. Ярилцлага авагчид ярилцлага өгөхөөс өмнө түүнтэй зүй бус харьцсан, эрхээ хасуулсан гэж үзэх үндэслэлтэй байвал энэ тухай холбогдох албан тушаалтан эсвэл эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ, тэдгээр нь ийм мэдэгдлийг шалгах үүрэгтэй.
198. Эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл бүрд, гомдол гаргаагүй байсан ч НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын 12 дугаар зүйлд заасны дагуу нарийн, шуурхай, шударга мөрдөн шалгах ёстой.
199. Эрүү шүүлт тулгах зэрэг ноцтой хэрэг гарсан тохиолдолд гомдлыг бие даасан байгууллага шалгах ёстой. Улс орнууд хууль сахиулах байгууллага, прокурор эсвэл эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийн асуудлыг хариуцдаг бусад байгууллагаас үйл ажиллагааны болон санхүүгийн хувьд хараат бус мөрдөн шалгах, гомдол гаргах механизмыг бий болгох ёстой. Ийм механизм нь үр дүнтэй, хараат бус байхын тулд мөрдөн шалгах хангалттай эрх мэдэл, улс төрийн дэмжлэг, хүний болон санхүүгийн нөөц, зөвлөмж гаргах, цаашдын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх чадвартай байх ёстой.
200. Бүх гомдол гаргагчид гомдол гаргасны үр дүнд гарах аливаа сөрөг үр дагавар, хэлмэгдүүлэлтээс хамгаалагдсан байх ёстой.

Нөхөн сэргээлт ба нөхөн төлбөр

201. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцсан хохирогчдод нөхөн төлбөр олгох нь хариуцлага хүлээлгэх, нэр төрөө сэргээхийг дэмжсэн хүний эрх юм. Нөхөн сэргээлт нь одоо байгаа үүргээ зөрчихийг эрс эсэргүүцэж буй дохио бөгөөд нөхөн төлбөр, нөхөн олговор, нөхөн сэргээлт, сэтгэл ханамжийн баталгаа, дахин давтагдахгүй байх баталгааг хослуулсан байх ёстой. Эдгээ арга хэмжээ нь учирсан хохиролтой пропорциональ байх ёстой.
202. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцсанаас хамгаалах арга хэрэгсэлд гэмт этгээдийг илрүүлэх, мөрдөн шалгах, яллах сэрэг хамаарах ёсгүй бөгөөд ийм үйлдэл үйлдэгдсэн гэдгийг тогтоох нь л чухал.
203. Эрүүдэн шүүж, зүй бус харьцсаны улмаас олж авсан нотлох баримтыг нотлох баримтад тооцохгүй нь ярилцлага өгч буй хүний эрх бөгөөд ярилцлага авч байгаа хүний хууль бус үйлдлээс хууль ёсны хамгаалах үр дүнтэй хэрэгсэл юм.

ЗУРГААДУГААР ЗАРЧИМ
ХЭРЭГЖИЛТ

Хэрэгжилтийн хувьд үр дүнтэй ярилцлага хийхэд үндэсний арга хэмжээ бат бөх байхыг шаарддаг.



204. Эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд улс орнууд зохих хууль эрх зүй, бодлого, зохицуулалтын болон институтийн тогтолцоог баталж, боловсруулж, ярилцлага авч буй байгууллагуудад шүүхийн хяналтыг баталгаажуулах ёстой. Үүнд үндэсний хэмжээнд холбогдох байгууллагуудын тогтвортой, уялдаатай хүчин чармайлт шаардагдана.
205. Эрх баригчид үндэсний хэмжээнд үр дүнтэй арга хэмжээ авснаараа дараах амлалтын хэрэгжилтээ хангадаг:

a. Ярилцлагын явцад зүй бус харьцах явдлыг арилгах, баталгаажуулах, олон улсын хүний эрхийн стандартыг дагаж мөрдөх

b. Ярилцлага хийх талаар хангалттай хэмжээгээр оновчтой сургалтуудыг холбогдох бүх байгууллагад явуулах

c. Ярилцлагын оновчтой, үр дүнтэй стратеги, практикийг боловсруулахад шинжээчид, мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчдын хамтын ажиллагааг дэмжих

d. Ярилцлагатай хийхтэй холбоотой хяналт, хариуцлагыг дэмжих, байгууллага дахь авлига, ял шийтгэлгүй үлдэх байдалтай тэмцэх

e. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцооны үйл ажиллагаа, шүүн таслах ажиллагааг сайжруулах.
206. Энэхүү амлалт нь зөвхөн эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцахаас урьдчилан сэргийлэх, хууль дээдлэх ёсыг сахиулах бодлого, практикийг боловсронгуй болгоход чиглээд зогсохгүй олон улсын жишигт нийцүүлэн олон нийтийн аюулгүй байдлыг сайжруулах хамгийн үр дүнтэй аргуудыг бий болгох зорилготой юм.



Дотоодын эрх зүйн орчин

207. Улс орнууд өөрсдийн хууль эрх зүйн орчныг системтэйгээр хянан үзэж, ярилцлага өгч буй хүмүүстэй харилцах харилцааг зохицуулсан хууль тогтоомж, тогтоол, бодлогын баримт бичгүүдийг баталж, хэвлэн нийтлэх ёстой. Ийм хууль тогтоомж, журам нь олон улсын эрх зүй, ялангуяа эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бусаар харьцахыг туйлын хориглосон эрх зүйн үүрэг, хариуцлагад бүрэн нийцсэн байх ёстой.
208. Үр дүнтэй ярилцлага хийхтэй холбоотой хамгаалалтын арга хэмжээг хууль тогтоомжид тусгахаас гадна гэр бүлд нь нэн даруй мэдэгдэх, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, өмгөөлөгч авах зэрэг асуудлыг тусгасан байх ёстой. Үүнтэй холбогдуулан ярилцлагын өмнө болон ярилцлагын үеэр хууль зүйн туслалцаа авах, төрийн дэмжлэгтэй өмгөөллийн хүртээмжийг бэхжүүлэх ёстой.
209. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бус харьцах гэмт хэрэгт зохих эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь үр дүнтэй ярилцлага явуулахад туслах гол түлхүүр юм. Ямар ч онцгой нөхцөл байдлыг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр зүй бусаар харьцахыг зөвтгөх үндэслэл болгож болохгүй.
210. Эрүү шүүлт, албадлагын дагуу олж авсан аливаа хэрэг хүлээсэн мэдүүлэг болон бусад мэдээлэл нь ийм хүчирхийлэл үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа болон мэдүүлэг гаргаснаас бусад тохиолдолд нотлох ач холбогдолгүй байхаар хууль эрх зүйн орчин хангах ёстой. Үндэсний хууль тогтоомж нь албадлага, хүчирхийлэлд буруутай хүмүүст хариуцлага тооцох ёстой.

Байгууллагын соёл ба чадавх

211. Байгууллагын удирдагчид харилцан ярилцах замаар үр дүнтэй ярилцлага хийхэд эерэг өөрчлөлтийн талаар сурталчлах ёстой бөгөөд тогтвортой амлалтыг бий болгох нь чухал. Байгууллагын соёлыг өөрчлөх ярилцлага хийх нь зөв засаглал, нарийн төлөвлөлт шаарддаг.
212. Байгууллагууд ярилцлага хийхтэй холбоотой үндэсний хууль эрх зүй, бодлогын хүрээнд гарсан бүх өөрчлөлтийг байгууллагын дүрэм, журамд нэгтгэж, ажилтнуудынхаа дунд өргөнөөр сурталчлах ёстой. Ярилцлагад шууд оролцож буй ажилтнуудад аливаа хууль эрх зүйн болон бодлогын шинэ шаардлагын бодит үр дагаврын талаар зааварчилгаа өгөх ёстой.
213. Ярилцлагын практикт утга учиртай, удаан үргэлжлэх өөрчлөлт хийх нь улс орнуудаас богино, дунд, урт хугацаанд хангалттай хүний болон санхүүгийн нөөцийн хөрөнгө оруулалт хийхийг шаарддаг. Ялангуяа тусгай сургалт, бичлэг хийх төхөөрөмж нэвтрүүлэх замаар чадвар, чадавхыг бэхжүүлэх учиртай.



214. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон бусад мөрдөн шалгах байгууллагууд дотоод болон олон улсын өмнө хүлээсэн үүргийнхээ дагуу үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагаа нь шүүх, олон нийтийн хяналтад ил тод, хариуцлагатай байх талаар арга хэмжээ авах ёстой.
215. Хууль сахиулах болон бусад тагнуулын байгууллагуудын институтийн чадавхыг бусад агентлагууд, судлаачид, эрдэм шинжилгээний нийгэмлэгтэй үргэлжилсэн бүтээлч харилцаа холбоогоор бэхжүүлэх боломжтой. Үндэсний хил хязгаарыг давж болох ийм хамтын ажиллагаа нь ярилцлага хийх практикийг сайжруулахад тус дөхөмтэй дүн шинжилгээ, мэдээллээр хангана.

Шүүх байгууллага

216. Шүүх, прокурорын хараат бус байдал нь үр дүнтэй ярилцлагын хэрэгжилтэд идэвхтэй байдлаар үүрэг гүйцэтгэх ёстой. Энэ нь мэргэжлийн болон шинжлэх ухааны бие даасан байдал, шүүх эмнэлгийн болон бусад холбогдох үйлчилгээнүүдэд бас хамаарна.
217. Шударга шүүхээр шүүлгэх эрх зэрэг үндсэн баталгааг хэрэгжүүлэхдээ шүүх эрх мэдэл ярилцлагад оролцогчдын эрхийг үргэлж хүндэтгэх ёстой. Үүний тулд тэд ярилцлагыг ямар хэлбэрээр явуулж байгаа, сэжигтэн, өмгөөлөгч, эрүүл мэндийн мэргэжилтэнтэй уулзах зэрэг хууль эрх зүйн болон процессын баталгааг хэрхэн эдэлж байгаа зэргийг харгалзан үзэх шаардлагатай.
218. Шүүх байгууллага нь мөрдөн шалгах байгууллага дахь ямар ч хамаагүй аргаар хэрэг хүлээлгэх хөшүүргийг халж, оронд нь ёс зүй, шинжлэх ухаанаар батлагдсан аргыг ашиглахыг дэмжих ёстой.
219. Шүүхийн эрх бүхий этгээд нь аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн хууль ёсны дагуу олж авсан нотлох баримтыг хүлээн зөвшөөрч, дарамт шахалт учруулсан, зүй бус харьцсаны улмаас олж авсан байж болзошгүйг анхаарах ёстой. Эрүүдэн шүүж, зүй бусаар харьцсан, албадлагын улмаас хийсэн мэдүүлгийг үл тооцох дүрмийн дагуу аливаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглахгүй байх ёстой.
220. Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих нь хууль ёсны эсэхийг тогтоохын тулд шүүхийн байгууллагад биечлэн авчирч, эсэргүүцэх боломжийг олгох ёстой. Тухайн хүнтэй зүй бусаар харьцсан байж болзошгүй гэж үзэх үндэслэл байгаа тохиолдолд прокурор, шүүхийн байгууллага албан тушаалынхаа эрхийн дагуу шалгалт явуулах ёстой. Илэрхий нотолгоо, гомдол гараагүй байсан ч шүүх эмнэлгийн үзлэг хийхээр хүсэлт гаргах ёстой.



221. Эцэст нь, эрүүдэн шүүсэн, зүй бусаар харьцсан буруутай этгээдүүдийг хуулийн өмнө авчирч, зохих шийтгэл ногдуулахын тулд шүүхийн эрх баригчид шаардлагатай бүх арга хэмжээг авах ёстой.

Түгээх

222. Улс орнууд уг зарчмуудыг холбогдох гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх эрх мэдлийн бүх байгууллагууд, эрх баригчид, ялангуяа хууль сахиулах болон бусад мэдээлэл цуглуулах байгууллагуудад түгээх ёстой.
223. Хяналтын байгууллага, иргэний нийгмийн байгууллага, бусад байгууллагатай хамтран түгээснээр мөрдөн шалгах байгууллагад итгэх иргэдийн итгэлийг бий болгоно.
224. Улс орнууд холбогдох байгууллагаас хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл цуглуулж мөрдөн шалгах, мэдээлэл цуглуулах ажиллагаанд үр дүнтэй ярилцлага хийх зарчмууд болон үйл явдлын талаар олон улсын болон бүс нутгийн холбогдох байгууллагуудад мэдээлэх ёстой.



“Ярилцлага хийх эдгээр зарчмууд нь нарийн шинжлэх ухаан, эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааны олон арван жилийн туршлага дээр үндэслэсэн бөгөөд нотлох баримт цуглуулах үр нөлөө, үнэн зөвийг сайжруулж, эрүү шүүлт тулгах, хэрэг албадан хүлээлгэх зэргээс үүдэлтэй шударга ёсны зөрчлөөс сэргийлдэг. Эдгээр нь гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа хүмүүс, түүнчлэн хохирогч болон гэрчийн үндсэн эрхийг хамгаалах, хууль сахиулах байгууллагад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх зорилготой юм.”

Хуан Э.Мендес,

*Мэргэжилтнүүдийн удирдах хорооны дарга,
НҮБ-ын Эрүүдэн шүүхийн тусгай илтгэгч асан.*